

ГАРЧИГ

1. Өмнөх үг	7
-------------------	---

НЭГ. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны хаврын ээлжит чуулганаар

1. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл	10
2. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр	11
3. Ардчилсан намын бүлгийн олон нийттэй харилцах цахим хуудсууд	12

ХОЁР. Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганаар батлагдсан хуулиуд

1. Шинээр батлагдсан хуулиуд:

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай	24
2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай	27
3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай	29
4. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай	32

2. Шинэчлэн найруулсан хууль:

1. Эрүүл мэндийн тухай	36
------------------------------	----

3. Нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиуд:

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай	43
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	45
3. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай	48
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	51
5. Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	55
6. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	59

7. Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 61
8. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 63

ГУРАВ. Улсын Их Хурлын 2011 оны хаврын чуулганаар батлагдсан Улсын Их Хурлын тогтоол, бусад шийдвэрүүд

1. Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах болон улсын тусгай хамгаалалттай зарим газар нутгийн хилийн заагийг шинэчлэн тогтоох тухай 66
2. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай */Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралт/* 69
3. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай 72
4. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай */Төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор/* 74
5. Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 76
6. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 79
7. Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай 81
8. Монгол Улсын 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2013-2014 оны төсвийн төсөөлөлийг зөвшөөрөх тухай 83
9. Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын 2010 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан батлах тухай 86

ДӨРӨВ. Гэрээ, Конвенци соёрхон баталсан хууль

1. Хөлөг онгоц, далайн эрх зүйд холбогдох Олон улсын конвенциуд, түүний нэмэлт протоколд нэгдэн орох тухай 90
2. БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын экспортын зээлийг ашиглах тухай Ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай 91
3. Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай 93
4. Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай 95

**ТАВ. 2011 оны эхний хагас жилд батлагдсан
Монгол Улсын Засгийн газрын тогтоолууд**

1. Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай	100
2. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай	101
3. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журам болон хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн байршил, үйл ажиллагааны чиглэл батлах тухай	106
4. Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд авто замын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	119
5. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай	127
6. Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	138
7. Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай	142
8. Хилийн чанадад амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэх тухай	143
9. Өмнөговь аймагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулах тухай	144
10. Зарим төрийн өмчит үйлдвэрийн газрыг төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах тухай	145
11. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай	146
12. Концессын зүйлийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай	147
13. Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг батлах тухай	148
14. Мал аж ахуйн салбарын 2011-2012 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай	150
15. Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай	153
16. Дулааны цахилгаан станцыг барих концессын гэрээний тухай	155

**ЗУРГАА. Улсын Их Хурлын 2011 оны намрын ээлжит
чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт** 157

**ДОЛОО. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд,
туслахууд болон бүлгийн ажлын албаны ажилтнуудын
утасны дугаар, цахим шуудангийн хаяг** 159

ӨМНӨХ ҮГ



Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулган ажлын 68 өдөр хуралдаж өндөрлөлөө.

Энэ хугацаанд бид өнөөгийн нийгмийн харилцаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, энэ төрлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчинг боловсронгуй болгох, сайжруулахад чиглэсэн 60 гаруй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэн баталлаа.

Энэхүү хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг тухай бүр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн хуралдаанаар хэлэлцэж, зохих шийдвэрүүдийг гаргаж байсны дээр зарим шаардлагатай хуулийн төслүүд дээр бүлгийн ажлын хэсгийг байгуулж ажиллалаа.

Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд “Эрүүл мэндийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай”, “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай”, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” зэрэг бие даасан хуулиудыг батлан гаргалаа.

Түүнчлэн энэ чуулганаар “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах болон улсын тусгай хамгаалалттай зарим газар нутгийн хилийн заагийг шинэчлэн тогтоох тухай”, “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай”, “Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай”, “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай”, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай”, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай”, “Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай” зэрэг Улсын Их Хурлын тогтоолуудыг хэлэлцэн баталлаа.

Мөн үүний зэрэгцээ энэ хаврын чуулганаар “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” зэрэг нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Хөлөг онгоц, далайн эрх зүйд холбогдох Олон улсын конвенциуд, түүний нэмэлт протоколд нэгдэн орох тухай”, “БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын Экспортын зээлийг ашиглах тухай Ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай”, “Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай”, “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай” зэрэг хуулиуд батлан гаргасныг онцлон дурьдмаар байна.

Ирэх намрын чуулганаар Улсын Их Хурлаар “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай”, “Монгол Улсын 2012 оны төсвийн тухай”, “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Шүүхийн тухай” багц хуулийн төсөл, “Газрын тухай” багц хуулийн төсөл, “Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслүүд болон “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэхээр шийдвэрлэсэн билээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг дээрх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүд дээр урьд урьдаас илүү идэвхи чармайлт гарган ажиллах болно.

Ингээд бүлгийн удирдлагын зүгээс бүлгийн гишүүддээ Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы хугацаанд идэвхи санаачлагатай ажиллаж, улс орны өмнө тулгамдсан олон чухал асуудлыг шийдвэрлэх шийдвэрийг амжилттай хэлэлцэн гаргасан явдалд талархал илэрхийлье.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН

НАМЫН БҮЛГИЙН АХЛАГЧ



Ч.САЙХАНБИЛЭГ

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2011 оны хаврын ээлжит чуулган 04 дүгээр сарын 05-наас 07 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл ажлын 68 өдөр үргэлжиллээ.

Энэ хугацаанд чуулганы нэгдсэн хуралдаан 27 удаа буюу 117 цаг, байнгын хороодын хуралдаан 87 буюу 143 цаг тус тус хуралджээ. Чуулганы хугацаанд бие даасан 9 хууль баталж, 21 хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Улсын Их Хурлын 25 тогтоол баталсан байна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг энэ чуулганы хугацаанд 23 удаа хуралдаж 76 асуудал хэлэлцэн, шаардлагатай гэж үзсэн холбогдох хууль болон Улсын Их Хурлын бусад, шийдвэрт 4 санал, дүгнэлт гаргаж, чуулганы нэгдсэн хуралдаан болон холбогдох байнгын хороодод хүргүүлсэн байна. Бүлгийн хуралдааны ирц 86.6 хувь байлаа.

2011 оны хаврын ээлжит чуулганаар Улсын Их Хурлын 76 гишүүнээс Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдэд 30 гаруй асуулга тавьсанаас Ардчилсан намын бүлгийн гишүүд 28 удаа асуулга тавьсан байна. Улсын Их Хурлын гишүүд энэ чуулганы хуралдаанд нийтдээ 31 удаа бичгээр асуулт тавьсаны 20 удаа тус намын бүлгийн гишүүд тавьжээ.

Энэ хаврын чуулганаар ажлын хэсэг 40 гарч ажилласнаас бүлгийн гишүүд 20 гаруй ажлын хэсэгт орж ажиллалаа.

Мөн бүлгээс байгуулсан “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай”, “Эрүүл мэндийн тухай” /шинэчилсэн найруулга/, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхийн эдийн биржийн тухай”, “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай” /шинэчилсэн найруулга/ зэрэг хуулийн төслийн 20 гаруй ажлын хэсэгт гишүүд ажиллалаа.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдээд байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл 45, хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүд 37 байна.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН ГИШҮҮД ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны хэвлэл, мэдээллийн хэсэг нь Улсын Их Хурлын 2011 оны хаврын чуулганы хугацаанд бүлгийн хуралдааны мэдээллийг нийт 405 удаагийн давтамжтай телевиз, радио, өдөр тутмын сонин, хэвлэлээр дамжуулан олон нийтэд хүргэлээ.

Мөн тус хэсэг нь Ардын эрх, Ардчилал, Нийгмийн толь, Монголын мэдээ, Өдрийн сонин, Улс төрийн тойм, Зууны мэдээ, Үндэсний шуудан, Өнөөдөр, Үнэн, Өдрийн шуудан, Монцамэ мэдээ зэрэг өдөр тутмын нийт 12 сонинд мониторинг хийсэн болно. Мониторингийн дүнгээс үзэхэд Улсын Их Хурлын 2011 оны хаврын чуулганы хугацаанд манай бүлгийн гишүүдтэй холбоотой мэдээ, ярилцлага дээр дурдсан сонин, хэвлэлүүдэд 600 гаруй удаа нийтлэгдсэн байна.

Хаврын чуулганы хугацаанд Сонгуулийн хуулийн тухай мэдээ мэдээлэл, ярилцлага олон удаа гарсаны дотор Ардчилсан намын бүлгийн гишүүд пропорциональ давамгайлсан сонгуулийн тогтолцооны талаар байр сууриа илэрхийлсэн ярилцлага, мэдээ мэдээлэл, нийтлэл цөөнгүй удаа хэвлэгджээ.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН ЦАХИМ ХУУДАС

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг нь бүлэг болон гишүүдийнхээ үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор www.democrats.mn веб хуудсыг ажиллуулаад жил гаруй хугацаа өнгөрч байгаа билээ. Уг сайтад Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн үйл ажиллагаа болон хуралдааныг үнэн, бодит, шуурхай мэдээлэх, Ардчилсан намаас Улсын Их Хуралд сонгогдсон 27 гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд явуулж буй үйл ажиллагаа, хийж бүтээсэн ажил, санаачилсан хууль, тогтоолын төслийн талаар цаг алдалгүй мэдээлдэг юм.

Иймээс иргэд, сонгогчид та бүхэн бүлгийн www.democrats.mn сайтнаас өөрийн сонгосон болон дэмждэг төрийн түшээдийн танилцуулга, санаачлан хийж буй ажлуудын талаарх мэдээллийг авах боломжтой. Мөн таны үзэл бодол, санал санаачлагыг хүлээн авах зорилготой anbuleg@yahoo.com электрон шуудангийн хаягийг ажиллуулж байна.

Мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийн үр шимээр манай орны бүх аймаг шилэн кабельд холбогдож хөдөө орон нутгийн иргэд цахим хуудсаар дамжуулан өөрийн сонирхсон мэдээллийг шуурхай хүлээн авдаг болоод байгаа билээ. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд энэхүү нөхцөл байдлыг харгалзан өөрийн үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр сонгогч олондоо хүргэж, Та бүгдийн санаа бодлыг сонсохыг эрмэлзэж байгаа юм.

Одоогийн байдлаар Ардчилсан намын бүлгийн гишүүдээс дараахь гишүүд хувийн сайтаа нээн ажиллуулж байна. Үүнд:

www.altankhuyag.mn

www.amarjargal.org

www.batbayar.com

www.batkhuu.mn

www.batsuuri.mn

www.gansukh.mn

www.zorigtd.mn

www.sedvanchig.mn

www.enkbold.mn

www.erdene.mn

зэрэг сайтууд тогтмол ажиллаж иргэд, сонгогчидтойгоо мэдээ, мэдээллээ хуваалцаж, тэдний санаа бодлыг сонсож байна.

ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ БУЮУ “SOCIAL NETWORK”

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг нь www.democrats.mn үндсэн веб хуудсыг ажиллуулахын зэрэгцээ олон нийттэй харилцаж, тэдгээрийн дуу хоолойг сонсох, чуулганаар хэлэлцэх хууль, тогтоолын төсөлд иргэдийн санал бодлыг тусгах зорилгоор олон нийтийн сүлжээ (social network) болох Facebook, Twitter, Flickr, Youtube зэрэг цахим хуудсуудыг “**Anbuleg**” гэсэн хаягтайгаар нээн ажиллуулж байгаа билээ.

FACEBOOK: www.facebook.com/anbuleg/

Нийгмийн сүлжээг тэргүүлэгч Facebook нь дээр дурдсан цахим хуудсуудаас хандалтын тоогоороо тэргүүлдэг бөгөөд Ардчилсан намын бүлэг өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон хуулийн төсөл, төслийн хэлэлцүүлэг зэргийг уг цахим хуудсанд байршуулдаг. Одоогийн байдлаар бүлгийн тус цахим хуудсанд Төсвийн тухай, Цаазаар авах ялыг халах тухай, Жолоочийн даатгалын тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг мөн Улсын Их Хурлын болон Орон нутгийн Хурлын сонгуулийг нэг өдөр явуулахын ач холбогдол, давуу тал сэдвээр Facebook цахим хуудас хэрэглэгчдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулж, тэдний санаа бодлыг хүлээн авч байгаа билээ.

Дараахь гишүүд өөрийн Facebook-ээрээ олон нийтэд мэдээллээ хуваалцаж тэдний дуу хоолойг сонсож байна.

www.facebook.com/Алтанхуяг_Норов/
www.facebook.com/amarjargal.rinchinnyam/
www.facebook.com/Altangerel_Purev/
www.facebook.com/Гаваагийн_Батхүү/
www.facebook.com/Batsuuri_ya/
www.facebook.com/Erdene_Batuul/
www.facebook.com/Gankhuyag_Davaajav/
www.facebook.com/GansukhLuimed/
www.facebook.com/Lambaa_Sambuu/
www.facebook.com/Цэрэнбатын_Сэдванчиг/
www.facebook.com/Temuujin_Kh/
www.facebook.com/ZandaakhuuEnkbold/

www.facebook.com/ErdeneSodnomzundui/

TWITTER: www.twitter.com/anbuleg

Тус twitter цахим хуудсыг нээн ажиллуулснаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийн товч агуулгыг 140 тэмдэгтэнд багтаан линк хэлбэрээр байршуулдаг. Бүлгийн дараахь гишүүд twitter хаягтай бөгөөд энэ хаягаараа иргэд сонгогчидтой өөрсдийн мэдээ, мэдээллээ хуваалцаж тэдний санаа бодлыг сонсож байдаг юм.

www.twitter.com/altankhuyag_mn

www.twitter.com/AmarjargalR

www.twitter.com/Nbatbayar

www.twitter.com/gavaa_batkhuu

www.twitter.com/tolin555

www.twitter.com/batsuuri_ya

www.twitter.com/ebatuul

www.twitter.com/BattulgaKh

www.twitter.com/boldlu

www.twitter.com/Gantumur_L

www.twitter.com/Gundalai_Lamjav

www.twitter.com/gankhuyagMP

www.twitter.com/S_Lambaa

www.twitter.com/TserenbatSedvanchig

www.twitter.com/Temuujin_Kh

www.twitter.com/enkboldz

www.twitter.com/erdene99

YOUTUBE: www.youtube.com/anbuleg

Уг цахим хуудсыг Ардчилсан намын бүлэг нээж ажиллуулснаар бүлгийн үйл ажиллагааг дүрс бичлэгээр олон нийтэд хүргэж байдаг.

www.youtube.com/amarjargalR

www.youtube.com/NBatbayar

www.youtube.com/BatkhuuGavaa

www.youtube.com/enkbold2006

нарын гишүүд энэ цахим хуудас дээр өөрсдийн үйл ажиллагааны дүрс бичлэгийг байнга байршуулж байна.

FLICKR: www.flickr.com/photos/56057347@N08/

Flickr нь фото хэлбэрээр олон нийтэд мэдээлэл хүргэхээс гадна бусад цахим хуудаснаас ялгаатай тал нь зургийг өндөр нягтаршилтай байршуулдаг. Ардчилсан намын бүлэг энэхүү цахим хуудсаар дамжуулж бүлэг болон түүний гишүүдийн үйл ажиллагааг фото хэлбэрээр олон нийтэд хүргэж байгаа билээ. Одоогоор Р.Амаржаргал болон Н.Батбаяр нарын гишүүд энэ цахим хуудсыг ашиглаж байна.

**Бид Таны санал санаачлагыг хүлээн авч хамтран ажиллахад
үргэлж нээлттэй байх болно.**

ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 12 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэн хуулийн төслийг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, боловсронгуй болгох талаар бүлгийн санал дүгнэлт бэлтгэх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан. Үүнд:

1. УИХ-ын гишүүн Ц.Сэдванчиг - ахлагч
2. УИХ-ын гишүүн Б.Батбаяр
3. УИХ-ын гишүүн Д.Кёкюшүзан Батбаяр
4. УИХ-ын гишүүн Я.Батсуурь
5. УИХ-ын гишүүн Г.Баярсайхан

Ажлын хэсэг ажиллах хугацаандаа бүлгээс өгсөн үүрэг болох “Бирж нь Засгийн газар, улс төрөөс хамааралгүй биеэ даасан байх” зарчмыг үндэс болгож ажилласан болно.

Үндэслэл, шаардлага:

Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 58-д "Мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэлийн тогтолцоог оновчтой болгох, түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх, улмаар эцсийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бий болгох";

“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.8-д "хөдөөгийн иргэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд шууд худалдаалах боломж бүрдүүлсэн мэдээллийн технологид суурилсан биржийн сүлжээ байгуулна";

Улсын Их Хурлын 2010 онд баталсан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.5.1-д "мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгох" гэж тус тус заасан.

Дээрх заалтууд нь “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль бий болох эрх зүйн үндэс болж байна.

Зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг зохион байгуулах чиг үүрэг бүхий биржийн арилжаанд оролцогчид нь арилжааны зуучлагч /брокер/ болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлагаар бий болсон хоршоод байх бөгөөд бирж дээр арилжих үйл ажиллагааг дуудлага худалдаа болон цахим хэлбэрээр гүйцэтгэж байхаар хуульд тусгасан.

Ингэснээр малчин, тариаланч, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид нь түүхий эдийн үнийн мэдээллийг тогтмол авах, түүхий эдээ өөрийн сонгосон үнээр борлуулах захиалга өгөх бололцоотой болж улмаар Монгол Улсын нийт 334 суманд мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг зуучилж борлуулах хоршоодын тогтолцоо бүрдэх боломжтой болж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛГЭЧ

- Хоршоо
- Малчид
- Фермерүүд
- Газар тариалан эрхлэгчид



БИРЖ



ТӨЛБӨР ТООЦОО, УРАМШУУЛАЛ



ХУДАЛДАН АВАГЧ

Урамшууллын тогтолцоо:

Биржийн арилжааг тогтвортой явуулах, оролцогчдын идэвхийг дээшлүүлэх зорилгоор бирж дээрээс худалдан авсан тухай боловсруулах үйлдвэрийн тодорхойлолтыг үндэслэн зөвхөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршооны гишүүн, газар тариалан эрхлэгчдэд урамшуулал олгож байхаар заасан.

Ач холбогдол:

Уг хууль батлагдсан нь малчид, тариаланчид бэлтгэсэн түүхий эдээ шууд болон ирээдүйд нийлүүлэхээр урьдчилан бирж дээр байршуулан борлуулах, цаг хугацаа, зардал мөнгө хэмнэх зэрэг чухал ач холбогдолтой. Мөн түүхий эд боловсруулах үйлдвэрүүд биржийн арилжаанаас түүхий эдээ цахим хэлбэрээр худалдан авах боломжтой болж байна.

Хууль батлагдсантай холбогдуулан түүхий эдийг бэлтгэх, хадгалах, тээвэрлэх стандартуудыг шинэчлэх болон заавал мөрдүүлэх нь чанар, аюулгүй байдал талаасаа нэн таатай орчин бүрдэх юм.

2008 оны Улсын Их Хурлын сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй нийцэж байгаа эсэх:

Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн “Монголдоо үйлдвэрлэе” гэсэн хэсэг дэх:

- Мал, малын гаралтай болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн сүлжээ бүхий биржийг техникийн дэвшилд тулгуурлан байгуулна. Мөн хөдөөгийн иргэд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ оршин суугаа газар бүртээ зах зээлийн үнээр арилжих нөхцөлийг бүрэлдүүлнэ гэсэн заалтад бүрэн нийцэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийг хэлэлцэн баталлаа.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт М.Ганбаатар

Утас: 99131522

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2011 оны 05 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай” хуулийн төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн 2011 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжих нь зүйтэй гэж үзсэн.

Уг хуулийг Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Үндэслэл, шаардлага:

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийн үйлчлэх хугацаа нь 2011 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон тул дахин хугацааг нь сунгахаар энэхүү хуулийн төслийг өргөн мэдүүлсэн юм.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг эмх замбараагүй олгох, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид шилжүүлэх, цааш нь дамжуулан худалдах явдал газар авч байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болохуйц хэмжээнд хүрсэн тул уг асуудлыг цэгцлэх, зөрчил дутагдлыг арилгах шаардлагатай болсон.

Хэрэгжих хугацаа, хүрэх үр дүн:

Ашигт малтмалын тухай хуульд заасан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл шинээр олгохыг хориглох юм.

Энэ хугацаанд Ерөнхийлөгчөөс ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.

2008 оны Улсын Их Хурлын сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй нийцэж байгаа эсэх:

Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн “Эрдэнийн хувь” гэсэн хэсэг дэх:

“Монгол Улс, орон нутгийн стратегийн хөгжил, үйлдвэржилтийн бодлогод зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд ойн сав, усны хагалбар газарт ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулахыг хориглоно” гэсэн зорилтод нийцэж байна.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт М.Ганбаатар

Утас: 99131522

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газар 2011 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, С.Ламбаа нарын 2007 онд санаачлан боловсруулсан “Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай” хуулийн төсөлтэй нэгтгэх үүрэг бүхий Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хорооны нэгдсэн ажлын хэсэгт Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд, Х.Тэмүүжин нар орж ажиллав. Ажлын хэсэг хуулийн төслүүдийг нэгтгэхдээ хоорондын уялдаа холбоо, хууль батлагдсаны дараа хэрэгжих боломж, үүсэх үр дагавар, бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах зэргийг нягтлаж, цаашид гарах үр дагавар, нийгэмд хэрхэн биелэлээ олж хэрэгжих тал дээр анхаарч ажилласан.

2007 оны 05 дугаар сарын 02-ны өдөр анх Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, С.Ламбаа нарын өргөн барьсан хуулийн төсөлтэй харьцуулбал зарчмын шинжтэй өөрчлөлтүүд тусгагдсанаас гадна нэр томъёоны нарийн тодорхойлолтууд, үйлчлэх хүрээ, баримтлах зарчим, мэдээллээр хангах зарчим зэргийг нарийвчлан тусгасан.

Үндэслэл, шаардлага:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” хэмээн заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д заасны дагуу Монгол Улсын иргэн нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээл хайх, хүлээн авах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж заасан, мөн Монгол Улсын Засгийн газраас 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарлахдаа хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр тусгасан нь уг хуулийг боловсруулж батлуулах үндэслэл болсон.

Иргэн, хуулийн этгээд холбогдох байгууллагаас мэдээлэл авахаар хандахад хуулийн нарийвчилсан зохицуулалт хийгдээгүйн улмаас байгууллагын нууцад хамааруулдаг. Тиймээс аливаа төрийн байгууллага нь тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн үйл ажиллагаатай хамааралтай асуудлаар мэдээлэл гаргах үүрэг бүхий эрх зүйн зохицуулалт оруулсан. Хуулийн байгууллагын 2007 оны судалгаагаар 360 гаруй хуулийн 30 хүрэхгүй хувьд л төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байсан бөгөөд ихэнх тохиолдолд төрийн нууцын болон байгууллагын нууцын тухай зэрэг мэдээлэл авахыг хязгаарласан зохицуулалтууд зонхилж байв.

Хуулийн зорилт улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахаас гадна иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл олж авах зардал, чирэгдэл, хүнд суртал, үл ойлголцол зэргийг бүрэн халахад чиглэгдсэн. Мөн төрийн ил тод, шударга, ажил хэрэгч, түргэн шуурхай, иргэдэд нээлттэй байдлыг бүрэн төгс хангах, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төр, иргэн хоёрын харилцан итгэлцлийг бэхжүүлэхийг зорьсон. Уг хууль нь 6 бүлэг, 25 зүйлээс бүрдэнэ.

Ач холбогдол:

Иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх нь Үндсэн хуулиар баталгаажсан байдаг. Тэр ч үүднээс мэдээллийн ил тод, нээлттэй байдал бол эрүүл ардчилсан нийгмийг төлөвшүүлэх суурь зарчим мөн гэж үздэг. Төрийн байгууллагуудын нээлттэй байдал нь иргэдийн зүгээс тавих хяналт болж чаддаг тул шударга ёс, зөв тэгш хуваарилалт, ялгаварлан гадуурхахгүй байх, хүнд суртлаас ангид, төрийн албан хаагчдын иргэдийнхээ төлөө үйлчилдэг цэвэр, тунгалаг, шударга нийгмийг төлөвшүүлэх чухал ач холбогдолтой билээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу боловсруулсан.

Ардчилсан намын мөрийн хөтөлбөртэй уялдах нь:

Мэдээллийн ил тод байдал гэдэг нь өөрөө эрүүл ардчилсан нийгмийг төлөвшүүлэх тулгуур зарчим мөн. Иргэд, хуулийн этгээдийг нээлттэй мэдээллээр хангах нь төр засгийн байгууллагуудад эргээд хяналт тавих зохицуулалтыг бий болгодог ба ингэснээр иргэн, төр засгийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх, цаашлаад төрийн аппаратын хүнд суртлыг арилгах зэрэг олон давуу талтай.

Төрийн ажил, үйлчилгээг тунгалаг, нээлттэй, олон нийтэд мэдээллийг ил тод түгээдэг болсноор Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийн “Шударга ёс-Иргэний нийгэм” бодлогыг хэрэгжүүлэх боломжтой. Иргэн өөрөө төрийн төлөө зүтгэдэг бус, төр засаг нь иргэнийхээ төлөө ажилладаг, хүнд суртлыг бүрэн арилгаж, чирэгдэл учруулдаггүй таатай, амгалан амьдралыг төлөвшүүлж чадах билээ. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдлэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэх эрх зүйн таатай орчинг бий болгоход энэхүү хуулийн гол зорилго оршино.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Б.Ганхөлөг

Утас: 93135486

ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан 2010 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” хуулийн төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн дэмжихээр шийдвэрлэж уг хуулийн төслийг судалж, боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллалаа.

Үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Боловсролын тухай” болон “Дээд боловсролын тухай” хуулиудын дээд боловсролын санхүүжилт, сургалтын төлбөр, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, суралцагчдын нийгмийн баталгаанд хамаарах заалтууд нь дээд боловсролын өрсөлдөх чадвар, чанарыг сайжруулах хөшүүрэг, зохицуулалт болж чадахгүй байна.

Өнөөдөр дэлхий дахинд дээд боловсролыг зардлаа олон дахин нөхөх хөрөнгө оруулалт, эдийн засгийн нэг салбар хэмээн үзэх хандлага өсөн нэмэгдэж байна.

Олон улсын хэмжээнд ийнхүү өрнөж буй нийтлэг үйл явц манай орны дээд боловсролын салбарт баримталж буй бодлого, үйл ажиллагаанд баримжаа болж ирсэн. 1991 оноос хойш дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг өргөтгөх, санхүүжилтийн эх үүсвэрийг олшруулах, сургалтыг зэрэглэсэн боловсрол олгоход чиглэсэн кредит цагт суурилсан тогтолцоонд шилжүүлэн, чанарын хөндлөнгийн үнэлгээний механизм бүрдүүлэх зорилт тавьсан.

Гэвч дээд боловсролын эдгээр шинэчлэлийг дэмжих санхүүжилт, хөрөнгө оруулалт, түүний дотор суралцагчдад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн эрх зүйн үндэс бүрдээгүй хэвээр байна. Мөн төрөөс зарах хөрөнгийн хэмжээг хорогдуулах хялбар дөт арга болж хувирсан байна. Дээд боловсролын санхүүжилтийн 80 хувь нь сургалтын төлбөрөөс бүрдэж байгаа өнөөгийн нөхцөлд судалгаа шинжилгээний ажил, сургалтыг дэмжих бүтэц, удирдлага, санхүүжилтийн тогтолцоог бий болгох боломжгүй байна.

Өнгөрсөн хичээлийн жилийн мэдээгээр дээд боловсрол эзэмшихээр суралцсан 161 мянган оюутны 71.4% нь хувийн зардлаараа суралцаж, 24.6% нь төрөөс ямар нэг хэлбэрээр санхүүгийн дэмжлэг авчээ. Төрөөс санхүүгийн дэмжлэг авч байгаа хамгийн том бүлэг нь төрийн албан хаагчдын хүүхэд (17 мянган суралцагч буюу төрөөс дэмжлэг авагчдын 43%) байна. 2008 онд дээд боловсролын нэг суралцагч сургалтын төлбөртөө дунджаар 505.8 мянган төгрөгийг өөрөө төлж, төсвөөс 148.8 мянган төгрөгийн (29.4%) дэмжлэг авсан гэж тооцож болохоор байна.

Манай орны нийт өрхийн 65.5 хувь нь их, дээд сургуульд сурдаг оюутантай, үүний 20.7 хувь нь хоёр оюутан бүхий гэр бүл байгаа бөгөөд нэг хүн дээд боловсрол эзэмшихэд зарцуулж буй хөрөнгийн хэмжээ сурч буй сургууль, мэргэжлийн чиглэлээс хамааран 6–11 сая төгрөг болж байна. Үүнээс үүдэн сургалтын төлбөр нь өрхийн ядууралд нөлөөлж буй нэг хүчин зүйл болоод байна.

Иймд дээд боловсролын санхүүжилтийн механизмыг бүхэлд нь авч үзэхийн хамт суралцах үедээ орлогогүй байгаа иргэддээ үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн болон нийгмийн хамгааллын цогц зохицуулалт бүрдүүлэх бодит хэрэгцээ, шаардлагыг иш үндэс болгон "Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай" хуулийн төслийг боловсруулсан байна.

Онцлог:

Дээд боловсролын сургалтын байгууллагад зохих шалгуур үзүүлэлтийг ханган өдрийн ангид суралцаж буй суралцагчид тэтгэлэг олгох бөгөөд хичээлийн нэг жилд олгох тэтгэлэгийн хэмжээ нь 10 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээтэй байхаар тусгав. Энэхүү тэтгэлгийг суралцах хугацаанд нь суралцагч нэг бүрт сар тутам олгоно.

Өнгөрсөн хичээлийн жилийн мэдээгээр дээд боловсрол эзэмшихээр 146.810 оюутан суралцаж байгаа бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгө нь өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуулиар 140.400 төгрөгийн 50% буюу 70.200 төгрөг олгогдохоор байгаа юм.

Шаардагдах хөрөнгө: 146.810 оюутан *70.200 төг *10 сар. Эх үүсвэрийг 2012 оны улсын төсөвт тусгана. Ойролцоогоор 105 орчим тэрбум төгрөг шаардагдах тооцоо байна.

Уг хууль 5 бүлэг 15 зүйлтэй бөгөөд 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Ач холбогдол

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль нь батладсанаар:

- Дээд боловсролын үйлчилгээ сонголттой, хариуцлагатай, чанартай болж эдийн засгийн хөшүүрэг бий болно.
- Дээд боловсролын сургалтын байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэр, бие даасан байдал баталгаажиж, үйл ажиллагаанд нь чанарын тогтвортой ахиц гаргах боломж бүрдэнэ. Дээд боловсролын сургалтын байгууллагад шууд болон суралцагчаар дамжуулсан төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр чанарын төлөөх хариуцлага нэхэх шаардлага үндэслэлтэй болно.
- Суралцагчид суралцах үндсэн зорилгодоо төвлөрөх, сурлагадаа ахиц гаргах, мэргэжил боловсролыг чанартай эзэмших боломж нь баталгаажна. Сургалтын төлбөрөө төлөх, амьжиргаандаа шаардлагатай орлогыг нэмэгдүүлэхэд авах тусламж дэмжлэгийн хүртээмж, хэмжээ нэмэгдэнэ.
- Суралцагч сургууль, хичээл багшаа сонгох замаар сургалтын чанарт тавих хяналтыг үр нөлөөтэй болгох, ирээдүйд эрхлэх хөдөлмөр, үйл ажиллагаандаа нийцүүлэн сурах үйл явцаа зохицуулах, боловсролын төвшинг сайжруулахад нөлөөлөх боломж дээшилнэ.
- Дээд боловсролыг дэмжих, суралцагчдад шаардлагатай нийгмийн үйлчилгээг хөнгөлөлттэй хүргэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн идэвх, санаачилга нэмэгдэнэ.
- Дээд боловсролын суралцагчдын сурах боломж нөхцөл сайжирч, тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөрөнгийн эх үүсвэр (эргэн төлөгдөх зээл) нэмэгдэнэ. Зээлийн хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх, хариуцлага хүлээх, итгэл даах хандлагыг төлөвшүүлж, нийгмийн итгэлцэл, иргэншүүлэх үйл явцад ахиц гарна.

**2008 оны Монгол Улсын Их Хурлын сонгуульд Ардчилсан
намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй уялдах нь:**

2008 оны Монгол Улсын Их Хурлын сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн “Эрүүл бие, саруул ухаан” гэсэн хэсэг дэх:

- Жил бүр дотоодын болон гадаадын их дээд сургуулиудад 1000-5000 оюутныг нэн шаардлагатай мэргэжлээр сургах “20 жилийн хөтөлбөр” гаргаж төрөөс санхүүжүүлнэ.

“Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” хуулийн төслийг Улсын Их Хурлын 2011 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Б.Одонтуяа

Утас: 93135497

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. “Эрүүл мэндийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2010 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжихээр шийдвэрлэсэн.

Уг хуралдаанаар “Эрүүл мэндийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг судалж боловсронгуй болгох чиг үүрэг бүхий бүлгийн ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

1. УИХ-ын гишүүн Г.Баярсайхан – ахлагч
2. УИХ-ын гишүүн Ц.Баярсайхан
3. УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
4. УИХ-ын гишүүн Л.Гүндалай
5. УИХ-ын гишүүн С.Ламбаа
6. УИХ-ын гишүүн Д.Одхүү
7. УИХ-ын гишүүн С.Эрдэнэ

Онцлог:

Эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулж байгаа нэр томъёо тодорхойгүйгээс хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч, хуучин мөрдөгдөж байсан хуульд эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, үүрэг хариуцлага тодорхой бус, өрхийн эмнэлгийн асуудал уг хуульд тодорхойгүй анхан шатны тусламж, үйлчилгээг хүн амд үзүүлдэг тус байгууллага үйл ажиллагаа явуулахад бэрхшээлүүд гарч, эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, шатлалын онцлог болон үйлчилгээний хүрээг тодруулах шаардлагатай байлаа.

1. Хот, хөдөөд манай иргэд, гадаадын улс орнуудад явж оношлогоо, эмчилгээ хийлгэх явдал эрс нэмэгдэж, ихээхэн хэмжээний мөнгөний урсгал гадагш гарч байгаатай холбоотойгоор эмчилгээ, оношлогооны өндөр технологи бүхий чадварлаг төв байгуулах, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг боловсронгуй болгох, төлбөртэй тусламж, үйлчилгээ явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, эрүүл мэндийн байгууллага олсон орлогоосоо эмч, ажилтнуудаа урамшуулах, нийгмийн асуудлыг шийдэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, шаардлагатай

тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээ худалдан авах, засварлах хангах боломжийг бүрдүүлэх замаар эрүүл мэндийн байгууллагыг хөгжихөд дэмжлэг үзүүлэхээр;

2. Эрүүл мэндийн талаар Үндэсний хөтөлбөр баталж, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихаар заасан.
3. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журмыг батлахаар тусгагдсан.
4. Хүний их эмчид эмчлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2 жил, эм зүйч, эм найруулагчид 5 жил, сувилагчид сувилах эрхийг 5 жил, эх баригчид 5 жил, нүүр амны их эмч, уламжлалт анагаахын их эмч, хүний бага эмчид эмчлэх зөвшөөрлийг тус тус хугацаагаар өөрчилсөн.
5. Мөн хуулийн 16 зүйлд Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна гэж тодорхой заалт оруулж, түүнчлэн нилээд хэдэн зүйл заалтаар хийх ажлын чиг үүргийг тодорхойлж өгснөөрөө онцлог юм.

Бүтэц:

Эрүүл мэндийн тухай хууль нь анх 1998 онд батлагдсан 2002, 2006 онд нэмэлт, өөрчлөлт орж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар байгуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 2009 онд тус тус уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж уг хуулиар эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэн эрүүл мэндээ хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах ба хуулийн шинэчилсэн найруулга нь 9 бүлэг 46 зүйлтэй.

Зарчмын шинжтэй орсон гол өөрчлөлтүүд нь:

Хуучин мөрдөгдөж байсан	Одоо мөрдөгдөж байгаа
28.1.3. Жирэмсэн, төрөх, төрсний	24.6.1. Жирэмсэн, төрөх, төрсний

<p>дараахь үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар/</p>	<p>дараахь 45 хоногт эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ /зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар/</p>
<p>11.5. Аймаг, нийслэл эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүргийн эрүүл мэндийн төв, эмнэлгийн даргыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж сум, дүүргийн Засаг дарга тус тус томилж чөлөөлнө.</p>	<p>12.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шатны Засаг даргатай зөвшилцөж, харьяа эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.</p>
<p>21.4. Улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээ, тэдгээрийг санхүүжүүлэх арга, төлбөрийн хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох бөгөөд уг тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журмыг Засгийн газар батална.</p>	<p>24.2. Улсын төсвөөс санхүүжих тусламж, үйлчилгээг үзүүлэх заавар, өвчин, эмгэгийн жагсаалт, санхүүжүүлэх арга, төлбөрийн хэмжээг тогтоох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүд хамтран батална.</p>
<p>16.1. Эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.</p>	<p>22.3. Магадлан итгэмжлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарыг орон тооны бус шинжээчдээр үнэлүүлж, дүгнэлт гаргана.</p>
<p>16.3. Магадлан итгэмжлэх, шинжээч ажиллуулах, журам, магадлан шинжлэх шалгуур, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>22.4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам, магадлан шинжлэх шалгуур, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>

<p>24.2-ыг хоёр салгаж, 24.7. нэмж оруулсан.</p>	<p>24.7. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, санхүүжүүлэх арга, төлбөрийн хэмжээ болон эрүүл мэндийн байгууллагыг сонгох журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллагын дарга, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>
<p>26.¹1. Эрүүл мэндийн байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд тэтгэвэрт гарахад нь 12 сарын, үүнээс сум, тосгон, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд 18 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагаас нь нэг удаа олгох;</p>	<p>29.2. Төрийн өмчийн эрүүл мэндийн болон боловсролын байгууллагад 25 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн тэтгэвэрт гарахад 24 сарын, эрүүл мэндийн бусад ажилтан тэтгэвэрт гарахад 12 сарын, өрхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн тэтгэвэрт гарахад 36 сарын, эрүүл мэндийн бусад ажилтан тэтгэвэрт гарахад 18 сарын үндсэн цалингаас нь тооцон ажиллаж байгаа байгууллагаасаа авах эрхтэй.</p>
<p>Шинээр нэмэгдсэн заалт</p>	<p>8.1.3. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, уламжлалт анагаах ухааны төв корпорацийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.</p>
<p>3.1.9. Эрүүл мэндийн анхан шатны тусламж гэж хүн амд эрүүл мэндийн зайлшгүй болон эмнэлгийн анхан тусламж үзүүлэхэд чиглэгдсэн эрүүл</p>	<p>16.2. Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын</p>

мэндийн анхан шатны байгууллагын үйл ажиллагаа;	үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.
Шинээр нэмэгдсэн заалт	30.3. Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод дайчлагдан ажилласан иргэнд нөхөн төлбөр, цалин хөлсний зөрүүг эрүүл мэндийн ажилтны нэгэн адил олгоно.
Шинээр нэмэгдсэн заалт	30.4. энэ хуулийн 30.3-т заасан иргэн тогтмол ажил эрхэлдэггүй бол цалин хөлсийг тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцно.
Шинээр нэмэгдсэн заалт	30.5. Эрүүл мэндийн ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу цалин хөлсний нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох бөгөөд тэдгээрийн төрөл, хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.
Шинээр нэмэгдсэн заалт	32.2. Үр хөндөх ажилбарыг эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгт тухайн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй их эмч гүйцэтгэнэ.
Шинээр нэмэгдсэн заалт	32.3. Үр хөндөх ажилбар гүйцэтгэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Шинээр нэмэгдсэн заалт	32.4. Нийгэмд аюул учруулж болзошгүй зарим өвчтэй хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх асуудлыг хуулиар зохицуулна.

Нэгдүгээр бүлэг: Хуулийн зорилт, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмын талаар;

Хоёрдугаар бүлэг: Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт эрүүл мэндийн удирдлагын тогтолцооны талаар;

Гуравдугаар бүлэг: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийн талаар;

Дөрөвдүгээр бүлэг: Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагын төрөл, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг, дүрэм эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг магадлан итгэмжлэхтэй холбоотой зохицуулалтын талаар;

Тавдугаар бүлэг: Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн талаар;

Зургадугаар бүлэг: Эрүүл мэндийн ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа, эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрмийн талаар;

Долдугаар бүлэг: Эрүүл мэндийн үйлчилгээ, хяналт эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх болон давтан сургах, байгууллагын тусгай эрх, эмгэг судлалын шинжилгээ хийх, халдварт өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх, оношлогоо, эмчилгээнд хэрэглэх арга, оношлогоо эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн шинэ аргыг турших, бүртгэх, нэвтрүүлэх, эмнэлгийн магадлагаа гаргах, сэтгэцийн өвчтэй хүнд үзүүлэх мэргэжлийн тусламж, үйлчилгээ, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, ханган нийлүүлэх, ахуйн шавьж мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, худалдах, эрүүл мэндийн мэргэжлийн хяналттай холбоотой зохицуулалтын талаар;

Наймдугаар бүлэг: Иргэний эрх, үүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын оролцооны талаар;

Есдүгээр бүлэг: Хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйлдлийг нуух, авлига авах, төрийн байгууллага, хувь хүний нууц задруулах зэргээр хуулиар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн албан тушаалтан, улсын байцаагчид хууль тогтоомжид заасны дагуу хүлээлгэх хариуцлагын талаар;

Ач холбогдол:

“Эрүүл мэндийн тухай” хууль батлагдан гарснаар эрүүл мэндийн байгууллага төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлэх, олсон орлогоосоо эмч, ажилтнууддаа урамшуулал олгох тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслээ худалдан авах, засварлах боломжийг бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагын бие даан хөгжих, төрөөс хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоон хүн амд чанартай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм.

Ардчилсан намын мөрийн хөтөлбөртэй уялдах нь:

Ардчилсан намын 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрийн “Эрүүл бие, саруул ухаан” гэсэн дэд хэсэгт “Багш, эмч нарт зориулсан мэргэжлийн улсын хэмжээний онлайн сүлжээг төрөөс дэмжиж, мэдээллийн технологи, зайн сургалт, оношлогоо, эмчилгээ хийх дэвшилтэт тоног төхөөрөмж ашиглах суурь чадвар эзэмшүүлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэж байгаа юм.

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2011 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд ердийн журмаар мөрдөгдөнө.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Ж.Отгонсүвд

Утас: 99051020

ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар авч хэлэлцэн дэмжихээр шийдвэрлэсэн.

Үндэслэл, шаардлага:

Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2008-2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 97-д “Хуулийн төсөл боловсруулалтын чанар, үр нөлөөг сайжруулах зорилгоор хуулийн төсөл боловсруулах ажиллагааг нарийвчлан зохицуулах, төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхой болгох, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар” мөн Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолд “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 4.1.1-д “Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй, боловсруулалтын шаардлага хангасан байх зарчмыг баримтлан эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлж, хийдэл, давхардал, зөрчлийг арилгах замаар хуулийг боловсронгуй болгох” зорилтыг дэвшүүлсэн.

Хууль тогтоомжийн шинэчлэлийн эхний шатанд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 400 гаруй хуулийн давхардал, хийдлийн зөрчлийг арилгах ажлыг одоогийн Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэх, эрх зүйн шинэчлэлийг эхлүүлэх нэгэн зэрэг олон хуульд өөрчлөлт оруулах боломж бүхий “багц хуулийн төсөл” гэсэн хэлбэрийг шинээр бий болгох шаардлага урган гарч байгаа юм.

Бүтэц:

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хууль 5 бүлэг, 27 зүйлээс бүрдэнэ. Зарчмын шинжтэй орсон гол өөрчлөлтүүд нь:

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 11.1.4 дэх заалтыг “Багц хуулийн төсөл” гэж шинээр нэмсэн;
2. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 15.10 дахь заалтыг “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулахаар багц хуулийн төслийг Засгийн газраас боловсруулан өргөн мэдүүлэх бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй” гэж тус тус заалтуудыг шинээр нэмж оруулсан.

Ач холбогдол:

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд боловсруулах “багц хуулийн төсөл” гэсэн хуулийн шинэ хэлбэрийг бий болгож ингэснээрээ хуулийн зөрчлийг тогтоох, уялдаа холбоог сайжруулах ажлыг богино хугацаанд үр дүнтэй явуулах эрх зүйн орчин бүрдэх юм.

Уг хуулийг 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр баталсан бөгөөд ердийн журмаар мөрдөгдөх юм.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Ж.Отгонсүвд

Утас: 99051020

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас санаачлан 2011 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн зарчмын хувьд дэмжихээр шийдвэрлэсэн.

Үндэслэл, шаардлага:

Улсын Их Хурлын 2009 оны 38 тоот тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-д Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгагдсан.

НҮБ-аас 1961 онд “Мансууруулах эмийн тухай”, 1971 онд “Сэтгэцэд нөлөөт эмийн тухай”, 1981 онд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” конвенцийг батлан гаргасан бөгөөд манай улс эдгээр конвенцид 1990, 1999, 2001 онуудад тус тус элсэн орсон байна.

2002 онд батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хууль мөрдөгдөж эхэлснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисод тавих хяналт сайжирч байгаа боловч хууль бус хэрэглээ нэмэгдэж байгаа нь төрийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагад тусгай зөвшөөрөл олгох харилцаа нь тодорхой бус байгаагаас гэмт хэрэг, зөрчил гарсаар байна.

Бүтэц:

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилт нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгоход оршино. Энэхүү хууль 5 бүлэг 18 зүйлтэй бөгөөд зарчмын шинжтэй орсон өөрчлөлтүүд:

Хуучин мөрдөгдөж байсан	Одоо мөрдөгдөж байгаа
Шинээр нэмэгдсэн заалт	4.1.4. Эмийн ургамлыг тарималжуулсан тохиолдолд сэтгэцэд нөлөөт бодис, түүний угтвар бодисыг үйлдвэрлэх, экспортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж болохоор зохицуулалт орсон.
8.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодисын үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.	8.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн угтвар бодисын үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллагын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.
Шинээр нэмэгдсэн заалт	8.3. Энэ хуулийн 4.1-д заасан зорилгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг ашиглах, импортлох зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.3.-т заасны дагуу олгоно.
8.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд бэлтгэх, үйлдвэрлэл явуулах, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгоно.	8.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд бэлтгэх, үйлдвэрлэл явуулах, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгоно.
9.1. Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүр гарган эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 14.5-д заасан байгууллагад тус тус ирүүлнэ.	9.1. Тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгж, байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өмнө гарган эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллага болон энэ хуулийн 14.5-д заасан Үндэсний хороонд тус тус хүргүүлнэ.
14.5. Энэ хуулийн 14.1.-14.4.-т заасан байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг	14.5. энэ хуулийн 14.1-14.4-т заасан байгууллагын авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

<p>үүрэгтэй байнгын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно.</p>	<p>бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул Үндэсний хороо орон тооны ажлын албатай байна. Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно.</p>
--	--

Ач холбогдол:

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар гарахгүй харин мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэл түгээлт, тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааны зохицуулалт илүү боловсронгуй болж, эдгээр бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн орчин бүрдэнэ.

Түүнчлэн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын төрлийг нэмэгдүүлэн, хэмжээг чангатган ногдуулах арга хэмжээг учруулсан хор уршиг, хохирлын хэмжээнээс хамааруулан тогтоосноор эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдахтай холбоотой зөрчил гарах нь багасна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2011 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Ж.Отгонсүвд

Утас: 99051020

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХЭД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг батлан, 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “БНМАУ-ын цол, одон, медалийн тухай” дүрмийн зарим зүйл заалтыг хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2011 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл болон “Зарлигийн зарим хэсгийг хүчингүй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2011 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Үндэслэл, шаардлага:

Улсын Их Хурлаас Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг батлан гаргахдаа “БНМАУ-ын цол, одон медалийн тухай дүрмийг батлах тухай” БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1990 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 148 дугаар зарлигийн холбогдох заалтуудыг өөрчлөөгүйн улмаас хууль, зарлигийн хооронд нэр томъёо, хүүхдийн тоо зэрэг зөрчилтэй байдал үүссэн байна.

Энэ нь 1990 оны зарлигийн дагуу 7 хүүхэд төрүүлж, өсгөсөн “Алдарт эх 2” одонтой эхэд 2010 оны хуулиар Эхийн алдар нэгдүгээр зэргийн одонг нөхөж олгоход хүндрэлтэй асуудал үүсч хуульд нэмэлт оруулах шаардлагатай болсон.

Бүтэц:

Уг тогтоолд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн Зарлигийн 1990 оны 06 дугаар сарын 30-ны 148 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтаар баталсан “БНМАУ-ын цол, одон медалийн тухай дүрмийг батлах тухай дүрмийн” 3.17. болон 5.29 дэх хэсгийг тус тус хүчингүй болгохоор заасан.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд төрүүлж өсгөсөн хүүхэд гэдэг ойлголтыг тодруулах болон үрчлүүлсэн хүүхдийг оруулахгүй байх тухай зохицуулалт, “Эхийн алдар” одонг олгох, хүүхдийн насны талаарх асуудлыг тодруулж зохицуулахаар тусгагдсан. Уг хууль зургаан зүйлтэй бөгөөд зарчмын шинжтэй орсон гол өөрчлөлтүүд:

Хуучин мөрдөгдөж байсан	Одоо мөрдөгдөж байгаа
1990 оны зарлигийн дагуу “Алдарт эх 2” одонгоор 8 буюу түүнээс дээш хүүхэд төрүүлж 8-аас доошгүй хүүхдээ өөрийн асрамжаар өсгөж хүмүүжүүлсэн бөгөөд 8 буюу түүнээс дээш хүүхэд нь эсэн мэнд байгаа эхийн бага хүүхэд нь 1 нас хүрсний дараа шагнадаг байсан.	3.3. энэ хуулийн 4.1.1 дэх “Зургаан хүүхэд төрүүлж өсгөсөн”, 4.1.2-ын “дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдгийг энэ хуулийн 3.2-ыг төсөөтэй хэрэглэж болно.
“Алдарт эх 2” одонгоор 5-8 хүртэл хүүхэд төрүүлж, 5-аас доошгүй хүүхдээ өөрийн асрамжаар өсгөж хүмүүжүүлсэн бөгөөд 5-аас дээш хүүхэд нь эсэн мэнд байгаа эхийн бага хүүхэд нь 1 нас хүрсний дараа шагнадаг байсан.	3.2. энэ хуулийн 3.1.1-д заасан “дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн” гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсныг хэлэх бөгөөд үүнд тэр үед 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд хамаарна. Харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй.
3.1.1. Дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцөлийг хангасан эх;	3.1.1. Дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь нэг нас хүрсэн энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцөлийг хангасан эх;

2011 онд “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон авах 39767 эх, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одон авах 92.000 эх байгаа гэсэн тооцоо хийсэн байна. 2011 оны төсөвт дээрх эхчүүд болон одоо авч байгаа эхчүүдэд нийт 33275,0 тэрбум төгрөгийн мөнгөн тусламж олгохоор төсөвт тусган хэрэгжүүлж эхлээд байна.

Хуучин одонтой байсан эхчүүдэд 2011 оны 2 дугаар сараас эхлэн жилд нэг удаа олгодог мөнгөн тусламжийг олгож байна.

Ач холбогдол:

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсанаар хүн ам өсөх, улмаар улс орны эдийн засгийн өсөлтийг хангах бодит нөхцөл бүрдсэн юм.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2011 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан бөгөөд ердийн журмаар мөрдөнө.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Ж.Отгонсүвд

Утас: 99051020

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2010 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж зарчмын хувьд дэмжихээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Их Хурал 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг хэлэлцэж баталсан.

Үндэслэл:

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хурдцыг дагаад Засгийн газрын худалдан авах ажиллагааны цар хүрээ жил тутам нэмэгдэж байгаа нь энэ харилцааг улам боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Үндэсний хөгжлийн стратеги, зорилтуудыг хангахад чиглэгдсэн дэд бүтцийн болон нийгмийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд худалдан авах ажиллагааны зөв тогтолцоонд шилжих нь чухал юм.

Хуульд худалдан авах ажиллагааны өнөөгийн бүрэн төвлөрсөн бус тогтолцоог халж, хагас төвлөрсөн тогтолцоонд шилжих бөгөөд худалдан авах ажиллагааны бодлого, хяналтын асуудал төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хэвээр үлдэн, харин улсын хэмжээнд хэрэгжих томоохон төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төвлөрүүлэн зохион байгуулах, түүнчлэн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр зарчмын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлт орсон.

Зохицуулах харилцаа:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд дараахь нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

1. Төрийн захиргааны байгууллагуудын өөрийн хэрэгцээний болон орон нутагт зохион байгуулж буй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанаас бусад Улсын болон бүс нутгийн чанартай эрчим хүч, авто зам, мэдээлэл, харилцаа холбоо, нарийн төвөгтэй цогцолбор бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг Засгийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжлийн байгууллага төвлөрүүлэн зохион байгуулахаар болсон.

Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшил болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-иос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулах шинэлэг зохицуулалтыг хуульд тусгасан.

Засгийн газар нь улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор батлах бөгөөд захиалагч байгууллага тухайн жилийн улсын төсөв батлагдсан даруй мэргэжлийн байгууллагын зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, захиалгыг гаргаж, төсөл, арга хэмжээ бүрийн хувьд холбогдох шаардлагатай мэдээлэл, техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн хамт мэргэжлийн байгууллагад хүргүүлж байх зохицуулалтыг тусгасан.

2. Захиалагчид шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг тодорхой хугацааны туршид, тогтсон үнээр нийлүүлэх нөхцөлийг тодорхойлж гүйцэтгэгчтэй байгуулдаг, олон улсын худалдан авах ажиллагааны нэг хэлбэр болох “ерөнхий гэрээ” гэсэн шинэ зохицуулалтыг бий болгон баталсан. Ерөнхий гэрээний хугацаа 3 хүртэл жил байна.

3. Төрийн захиргааны төв болон бусад байгууллагад төвлөрсөн эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, төвлөрлийг сааруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэн орон нутгийн эрх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр тухайн орон нутагт хэрэгжих бүх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг ямар нэгэн

төсөвт өртөг хамаарахгүйгээр тухайн орон нутгийн засаг захиргааны нэгж дангаараа хэрэгжүүлэх шинэ зохицуулалтыг бий болгон баталлаа.

4. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулж байх өөрчлөлтийг тусгалаа.

5. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тендерийн ил тод байдал, хяналтыг сайжруулах, тендерийн үр өгөөж, чанарыг дээшлүүлэх зорилгоор иргэний нийгмийн болон олон нийтийн бусад мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулж захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, мониторинг аудит хийлгэж байх журам тогтоож мөрдөх шинэ заалтыг тусгасан.

6. Тендер шалгаруулалтыг 45 хоногийн хугацаатай болгож, уг хугацааг зөвхөн нэг удаа 30 хоногоор Төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагын саналыг үндэслэн сунгаж байх өөрчлөлт орууллаа.

7. Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон иргэний болоод, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхээ хамгаалуулах гол хэрэгсэл болох гомдол гаргах эрхийн зохицуулалтыг шинэчлэн найруулж тусгасан.

Түүнчлэн тендерт оролцогчид тендерийн үйл ажиллагаатай холбоотой гомдлоо хэрхэн яаж гаргах зохицуулалтыг нарийвчлан зааглаж өгсөн.

8. Худалдан авах ажиллагаанд оролцогчдын хариуцлагыг дээшлүүлэх, аливаа хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцлагын тогтолцоо, механизмыг оновчтой хэлбэрээр тогтоох, тэдэнд хүлээлгэх захиргааны хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгож байхаар тогтсон. Түүнчлэн худалдан авах ажиллагаанд оролцогч албан тушаалтан ялангуяа захиалагчийн ерөнхий менежер, гүйцэтгэх захирал, үнэлгээний хорооны гишүүнийг төрийн албанаас халах хүртэл арга хэмжээ авч байхаар тусгасан.

9. Хуульд цэргийн анги нэгтгэлийн болон хорих ангийн өөрийн хэрэгцээнд шаардлагатай ажлыг ял эдэлж буй этгээд болон цэргийн ажиллах хүчээр гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзвэл хуульд

заасан тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүйгээр худалдан авах, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгохтой холбогдуулан хугацааг нарийвчлан заах, урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулан тооцох, тендерт оролцохыг сонирхогч этгээдийг өрсөлдөх тэгш боломжоор хангах үүднээс хязгаарлагдмал тендер шалгаруулалтын урилгыг худалдан авах ажиллагааны цахим хуудаст нийтлэх тухай зэрэг зохицуулалтыг хуульчилсан.

Ийнхүү Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд дээрх зарчмын өөрчлөлтийг тусган хуулийг баталлаа.

Энэ хууль 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Э.Мандуул

Утас: 93135491

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн бүлгийн хуралдаанаараа хэлэлцэн зарчмын хувьд дэмжсэн.

Монгол Улсын Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэх зарчмын шийдэлд хүрч, улмаар “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдөр батлан гаргалаа.

Үндэслэл, шаардлага:

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийг 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хурлаар баталж, улмаар 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн билээ.

Хуулийг мөрдөж эхэлснээс хойшхи хугацаанд энэ хуулийн зарим заалт амьдралд нийцэхгүй байгаа, зарим төрлийн ажил үйлчилгээнд тогтоосон тэмдэгтийн хураамжийн хэмжээг эргэн авч үзэх талаар иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудаас саналаа илэрхийлж байсны дотор согтууруулах ундааг худалдаа, түүгээр үйлчилгээ эрхлэх, химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах тусгай зөвшөөрлийг олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг үндэслэлгүйгээр өндөр тогтоосон тухай Улсын Их Хурал, Засгийн газарт хандан албан ёсоор байр сууриа илэрхийлж байсан юм.

Засгийн газар шинэчлэн найруулсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар тэмдэгтийн хураамжийн хэмжээг олон нийтээс ирүүлсэн саналыг үндэслэн, амьдралд нийцэхгүй байгаа зарим төрлийн тэмдэгтийн хураамжийн хэмжээнд өөрчлөлт оруулах, ялгавартай авч үзэх чиглэлээр Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2011 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн юм.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, Н.Батбаяр нараас Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах, зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг 2011 оны 05 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн юм. Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар салбарын мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн 4 жил тутам тогтоож байхаар өөрчлөлт хийх саналыг тусгасан.

Хуулиар зохицуулсан асуудал:

Нэг. Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр дараахь зарчмын асуудлыг шийдвэрлэлээ.Үүнд:

1. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон хуулийн 2 дугаар бүлгийг бүхэлд нь авч үзэж, хураамжийн хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос нь хамааруулан энэ хуулиар, түүнчлэн хуулиар тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож байх нэмэлтийг 6 дугаар зүйлд тусгалаа. Ингэхдээ төрийн нэгдсэн бодлогоор зохицуулагдах, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, нийтийн эрх ашиг сонирхлын үүднээс хуулиар зайлшгүй тогтоох зарим төрлийн үйлчилгээ тухайлбал галт зэвсгийг худалдах, эзэмших, улсын хилээр оруулах, түлш, эрчим хүч, архи, спирт, тамхины үйлдвэрлэл, мэдээлэл, харилцаа холбоо, цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энерги зэрэг чиглэлээр зөвшөөрөл олгоход ногдуулах тэмдэгтийн хураамжийг энэ хуулиар тогтоож, эдгээрээс бусад төрийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл, эрх олгох үйлчилгээнд ногдуулах хураамжийг хуулиар тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож байх зохицуулалтыг тусгалаа.

Аймаг, нийслэлийн Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгох үйлдвэрлэл, үйлчилгээнд хураах хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож байхаар хуульчиллаа. Үүнд агаарт бохирдуулдаг бодис гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээнд тусгай зөвшөөрөл олгох, ан амьтан эзэмших зөвшөөрөл олгох, ус ашиглуулах гэрчилгээ олгох, үйлдвэрлэлийн зориулалтаар ан амьтан агнах, барих гэрээ байгуулах, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох зэрэг 30 орчим ажил, үйлчилгээг хамарч байна.

2. Тэмдэгтийн хураамжийн хэмжээнд өөрчлөлт оруулахдаа дараахь асуудлыг шийдвэрлэлээ:

Бизнес эрхлэгчдийн ачааллыг бууруулах, амьдралд нийцэхгүй байгаа хураамжийн хэмжээнд өөрчлөлт оруулах чиглэлийг баримтлав.

Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 400.000-1.000.000 төгрөг, аймгийн төвийн суманд 240.000-600.000 төгрөг, бусад суманд 120.000-300.000 төгрөг, спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 600.000-1.500.000, аймгийн төвийн суманд 320.000-800.000 төгрөг, бусад суманд 200.000-500.000 төгрөг байхаар бууруулан тогтоолоо.

3. Химийн хортой болон аюултай бодис импортлох, экспортлох, худалдах, ашиглахтай холбоотой тэмдэгтийн хураамжийн хэмжээг бодитой тогтоох үүднээс химийн бодисын хор аюулын зэрэглэлээс хамааруулан ялгавартай тогтоолоо. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.4 дэх хэсэгт заасан Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн бодисын жагсаалтад орсон бодисуудыг импортлох, худалдах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг 10.000.000 төгрөг, бусад химийн бодис түүний дотор ахуйн болон энгийн хэрэглээний химийн бодисыг импортлох, худалдах, ашиглах үйлдвэрлэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийг бууруулан тогтоолоо.

4. Иргэний бүртгэлийн үйлчилгээний хураамжтай холбоотой 1000 төгрөгөөс бага хураамжийг бүхэлд нь хүчингүй болголоо. Энэ өөрчлөлтөөр төрсний гэрчилгээ, гэрлэлтийн гэрчилгээ олгох, гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгох, гэрлэлт сэргээснийг бүртгэх, эцэг, эх тогтоосныг бүртгэх зэрэг үйлчилгээнд тэмдэгтийн хураамж авахгүй байхаар боллоо.

Хоёр. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлан гаргалаа.

Тогтоолоор хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараахь асуудлыг шийдвэрлэлээ:

1. Хуульд заасан хязгаарт багтаан 2011 оны 07 дугаар сарын 01-ний дотор тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоохыг Засгийг газарт үүрэг болгож, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мөн хугацаанд батлан гаргахыг зөвшөөрлөө.

2. Улсын тэмдэгийн хураамжийн хэмжээг бууруулан тогтоосон заалтыг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр буцаан хэрэглэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан буцаан олголтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болголоо.

3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоог багасгах, шат дамжлагыг бууруулах шаардлагад нийцүүлэн тусгай зөвшөөрлийн тоог багасгах, хугацааг бодитой тогтоох, тусгай зөвшөөрлийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх асуудлыг судлан үзэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, аж ахуйн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгож байгаа байдал, түүнийг зохицуулж байгаа хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хариуцлага тооцон ажиллахыг Засгийн газарт тус тус үүрэг болголоо.

Ач холбогдол:

Хуулийг хэрэгжүүлэх шатанд гарч ирсэн амьдралд нийцэхгүй, зөрчилтэй зүйл, заалтыг өөрчлөх, боловсронгуй болгох асуудлыг шуурхай шийдвэрлэж, улмаар бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, тэмдэгтийн хураамж ногдуулах үндэслэлийг сайжруулах, амьдралд илүү ойр, бодитой байхад чиглэгдсэн өөрчлөлтийг тусган шийдвэрлэсэнд энэ хуулийн ач холбогдол оршиж байгаа юм.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд харин хураамжийн хэмжээг бууруулан тогтоосон тухайн заалтыг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэлээ.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Э.Мандуул

Утас: 93135491

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж 2011 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо 2011 оны 05 дугаар сарын 31, 06 дугаар сарын 07-ны өдрүүдэд авч хэлэлцэн Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан.

Үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлд захиргааны хэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх байгуулж болно гэж заасныг үндэслэн Улсын Их Хурал 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг батлан 2004 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн дагаж мөрдүүлсэн. Давж заалдах болон хяналтын шатны журмаар байгуулагдсан шүүхийн тогтолцоонд хандах иргэдийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын ачаалал өссөн билээ. Үүнтэй холбогдуулж шүүхийн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, захиргааны хэргийн шүүхийн тогтолцоог боловсронгуй болгож Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуулийн заалттай уялдуулах зорилгоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах шаардлага зүй ёсоор тавигдсан.

Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдааны шийдвэрийг үндэслэн 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр байгуулагдсан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2011 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс бүтэц, зохион байгуулалтын ажлыг жигдлэн үйл ажиллагаагаа явуулж эхлүүлсэн билээ. Шүүхээр шийдвэрлэх хэргийн харьяалал, давж заалдах гомдлыг хүлээн авах, хэрхэн гаргах зэргийг тодорхой болгох шаардлагыг харгалзан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулах хууль, эрх зүйн үндэслэл бий болсон.

Бүтэц, зохицуулах харилцаа:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь хуульд нэмэлт оруулах, зарим зүйл, заалт, хэсэг, өгүүлбэрийг өөрчлөн найруулах болон өөрчлөлт оруулах гэсэн 4 ерөнхий зүйлээс бүрдэнэ. Үүнд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэж байхаар 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг өөрчлөн найруулсан. Мөн зүйлд Улсын Дээд шүүх давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэж байхаар шинэ хэсэг нэмэх зэрэг өөрчлөлтүүд тусгагдсан.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлагдсан өдрөөс буюу 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Б.Ганхөлөг

Утас: 93135486

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж 2010 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг уг хуулийн болон холбогдох бусад хуулийн төслүүдийг 2010 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжинээр ахлуулсан, Н.Батбаяр, З.Энхболд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллав.

Үндэслэл, шаардлага:

Засгийн газрын 2009 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5.2.15-д “Тагнуулын байгууллагын тухай хуульд тагнуулын байгууллагын чиг үүргийг тодотгох, төрийн тусгай алба мэргэшсэн, тогтвортой ажиллах зарчмыг хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна” гэж заасны дагуу тагнуулын байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүний нөөцийн бодлогыг шинэчлэх, дарга, удирдлагыг томилж чөлөөлөх, техник, технологийн дэвшилд тулгуурлан үйл ажиллагааг боловсронгуй болгох тал дээр анхаарч, үүнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тусгав.

Төрийн нууцын тухай болон Гүйцэтгэх ажлын тухай хуульд Тагнуулын Ерөнхий газрын зарим чиг үүргийг тодорхойлсон боловч тагнуулын байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчмыг агуулах 1999 онд батлагдсан Тагнуулын байгууллагын тухай хуультай уялдуулж өгөөгүйгээс зарим төрлийн зохицуулалт хэрэгжиж чаддаггүй байв. Техник, технологийн дэвшилтэй холбоотой асуудлууд, тэрчлэн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, терроризмтой тэмцэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хуулиар төрийн аль ч байгууллагад хариуцуулаагүй байсан нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болсон.

Ач холбогдол:

Тагнуулын байгууллагын бүрэн эрхэд үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулан хэрэгжүүлэх, үүнтэй холбоотой асуудлаар санал, дүгнэлт гаргуулах, төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зэрэг чухал асуудлуудыг нэг мөр шийдвэрлэснээр гүйцэтгэх ажил явуулдаг эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчин улам боловсронгуй болж терроризмоос сэрэмжлэх, гүйцэтгэх ажлын явцад хүний эрх зөрчигдөхөөс сэрэмжлэх боломж бүрдэх зэрэг зохион байгуулалтын томоохон дэвшил дагуулсан. Төрийн нууцтай холбоотой асуудлыг зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авч ажиллах, тухайн асуудлаар санал, дүгнэлт боловсруулах, түүнчлэн гадаадын тусгай алба, байгууллага, гэмт бүлэглэлтэй холбоотой тусгай үүрэг гүйцэтгэх албан хугацааг тогтоох, онц шаардлагатай тохиолдолд олон хүнд нөлөөлөх хэрэгсэл, албаны нохой ашиглах, дарга болон дэд даргад тавигдах шаардлага, тэдгээрийг томилох, чөлөөлөх зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг нэг мөр шийдвэрлэж чадсан.

Ардчилсан намын мөрийн хөтөлбөртэй уялдах нь:

2008-2012 оны Улсын Их Хурлын сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн “Эзэн Монгол хүн” бодлогод “Төр иргэнээ гадна, дотны аливаа халдлагаас батлан хамгаална, мөн орчин үеийн олон улсын харилцаа, шинэ хандлагад тохирсон батлан хамгаалах бодлого хэрэгжүүлж энхийг сахиулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно” хэмээн тусгасныг бодитоор хэрэгжих нөхцөл, бололцоог бүрдүүлж чадсан.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Б.Ганхөлөг

Утас: 93135486

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын Засгийн газраас “Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн зарчмын хувьд дэмжсэн.

“Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар баталлаа.

Үндэслэл, шаардлага:

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно” гэж заасан нь энэ хуулийн төслийн төрийн албан тушаалтны цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтоол гаргаж шийдвэрлэх үндэслэл болсон.

Хамрах хүрээ:

Энэ хуулиар төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоож, энэ итгэлцүүрээр төрийн албан хаагчдын цалинг Засгийн газар тогтоож байхаар боллоо.

Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоол батлагдан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг баталсан.

Ач холбогдол:

Уг хууль болон тогтоол батлагдсанаар төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны

зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээг тогтоох асуудал шат дамжлагагүй, шуурхай зохицуулагдах боломжийг бүрдүүлж өглөө.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Э.Мандуул

Утас: 93135491

ЗАРИМ ГАЗАР НУТГИЙГ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ БОЛОН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ЗАРИМ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 03 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах болон улсын тусгай хамгаалалттай зарим газрын хилийн заагийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хэлэлцэн хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн.

Уг тогтоолыг Монгол Улсын Их Хурал 2011 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталсан.

Үндэслэл, шаардлага:

Дэлхийн улс орнууд байгалийн нөөц баялагт түшиглэн эдийн засгаа хөгжүүлсээр ирсэн ч түүнээс гарах сөрөг үр дагавар, хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан экосистемийн гажуудал улам бүр газар авсаар байна. Үүнээс үүдэн өнөөдөр байгалийн баялаг, эдийн засгийн чадавхигүй болтлоо доройтсон улс орнуудын гашуун жишээ олон байна.

Манай улсын хувьд цөлжилт, хуурайшилтаас илүүтэйгээр ашигт малтмалын эмх замбараагүй олборлолт, нөхөн сэргээлтийг хийхгүй байх, үржил шим бүхий өнгөн хөрсийг хуулж байгаагаас малын бэлчээр хомсдох, гол мөрөн, нуур цөөрөм ширгэх, ой мод сүйдэх зэрэг байгаль экологид үзүүлэх сөрөг үзэгдлүүд газар авч олон мянган жилийн хугацаанд бүрэлдэн тогтсон амьтан, ургамал бүхий экосистемийн тэнцвэрт байдал алдагдах болсон.

Иймд экологийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьсан менежмент бүхий тогтолцоог бэхжүүлэх, унаган байгалаа хамгаалах, байгаль орчны тэнцлийг хангах мөн ногоон эдийн засаг, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор зарим газар нутгийг үе шаттайгаар улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай юм.

Хамрах хүрээ:

Ангилал	Байршил
Дархан цаазат	Булган аймгийн Тэшиг, Хутаг-Өндөр
	Сэлэнгэ сумын нутгийг дамнан орших Зэд-Хантай-Бүтээлийн нурууд
	Улаан тайгын байгалийн цогцолборт газрын хилийн заагт Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Баянзүрх сумын нутгийн зарим хэсэг
Байгалийн цогцолборт газар	Хөвсгөл аймгийн Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумын нутаг дэвсгэрт орших Тэнгис-Шишгэдийн голын ай сав
	Ховд аймгийн Булган сумын Булган голын байгалийн нөөц газрыг мөн сумын Их Онгог орчмын зарим газар нутгаар

Мөн тусгай хамгаалалттай газар нутагт амьдарч, үйл ажиллагаа явуулдаг иргэдэд Газрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу газар эзэмших, өмчлөх эрхээ эдлэх хууль ёсны боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын хилийн заагаас Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон болон Ханх сумын төвийн эдэлбэр газрыг чөлөөлж, Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Ханх сумын зарим хэсгийг хамруулан уг байгалийн цогцолборт газрын хилийн заагийг, Мянган-Угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хилийн заагт Ховд аймгийн Цэцэг, Мөст сумын зарим хэсгийг хамруулан уг байгалийн цогцолборт газрын хилийн заагийг, Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хилийн заагт Ховд аймгийн Үенч сумын нутгийн зарим хэсгийг хамруулан уг байгалийн цогцолборт газрын хилийн заагийг, Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын хилийн заагаас Хэнтий аймгийн Дадал сумын төвийн эдэлбэр газрыг чөлөөлөн уг байгалийн цогцолборт газрын хилийн заагийг тус тус шинэчлэн тогтоосон.

2008 оны Улсын Их Хурлын сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй нийцэж байгаа эсэх:

Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн “Байгаль ээж” гэсэн хэсэг дэх:

- Эхний зарчим нь байгаль орчин гэдэг бодлого баримтлах,
- Сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн улмаас сүйдсэн экосистемийг нөхөн сэргээх ажлыг эхлүүлэх,
- Байгаль орчинд хохирол учруулсан аливаа үйл ажиллагааг хатуу цээрлүүлэх хуулийн үйлчлэлийг бодитой хэрэгжүүлэх гэсэн нь тогтоолын үзэл баримтлалтай нийцэж байна.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт М.Ганбаатар

Утас: 99131522

ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 1999 ОНЫ 27 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах тухай" Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2011 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит хуралдаанаараа хэлэлцэн дэмжихээр шийдвэрлэсэн.

Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр баримтлах бодлого”-д хүнс, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэхэд оршино гэж тодорхойлсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 11 сарын 29-ний 250 тоот зарлигаар хүнсний ногооны гаалийн албан татварыг нэмэгдүүлэх, өөрчлөх саналыг судлан санал боловсруулах арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосон.

Практик шаардлага:

“Хүн амын хоногт хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний зөвлөмж хэмжээ”-гээр Монгол Улсын хэмжээнд жилд 240 мянган тонн гурил, 164 мянган тонн хүнсний ногоо хэрэглэх шаардлагатай байдаг.

“Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр, “Атрын 3 дахь аян, Тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэний үр дүнд 2010 оны ургацийн дүнгээр хүн амын хэрэгцээт гурилын 100 хувь, хүнсний ногооны 53.7 хувь тэр дундаа сонгино, байцаа, шар лууван, шар манжин

зэрэг таримлуудын 75 хувийг дотоодын ургацаас тус тус хангах боломж бүрдсэн.

Үндсэн зорилго:

- Ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хангах;
- Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих юм.

“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад орсон өөрчлөлт:

Бүлэг	Зүйл №	Үндэсний код	Барааны бичиглэл	Албан татварын хувь, хэмжээ
07	07.01	0703.10.00	Сонгино	15
		0704.90.10	Байцаа	15
		0706.10.10	Шар лууван	15
		0706.10.20	Шар манжин	15

[/Дээрх 07 дугаар бүлгийг 2011 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

Мөн хавсралтын 11 дүгээр бүлгийн 11.01, 11.02 дахь зүйлийн “гурил”-ийн албан татварын хувь хэмжээг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтуудаар импортлосон бол 07 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01 хүртэл 15 хувь байхаар, 04 дүгээр сарын 01-нээс 07 дугаар сарын 01 хүртэл 5 хувь байхаар, бусад боомтоор импортлосон бол жилийн турш 15 хувь байхаар тогтоосон болно.

Ач холбогдол:

- Тогтоол батлагдсанаар газар тариалангийн дотоодын үйлдвэрлэгчдийн санхүүгийн чадавхи сайжирч, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдэж, ажлын байр бий болох, улмаар улсын төсвийн орлогын хэмжээ нэмэгдэнэ.

- Эх орны хөрсөнд тарьж, ургуулсан хүнсний ногоо, дотоодод үйлдвэрлэсэн гурил хэрэглэснээр иргэдийн хүнсний аюулгүй байдлын баталгаа сайжрах юм.

“Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг 2011 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Уг тогтоолыг 2011 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн зөвлөх Д.Бэхбат

Утас: 93135498, 99089799

ГАМШГААС ХАМГААЛАХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн 2011 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн төслийг судалж, боловсронгуй болгох, бүлгийн санал дүгнэлт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр-ажлын хэсгийн ахлагч, Д.Одхүү нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан.

Уг тогтоолыг Монгол Улсын Их Хурлын 2011 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Үндэслэл, шаардлага:

Дэлхийн улс орнууд сүүлийн жилүүдэд нэн тэргүүнд авч үзэх болсон байгалийн давагдашгүй хүчин зүйл, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн аюул заналын давтамж ойртож, хүний амь нас, эрүүл мэнд хохирох, байгаль экологид сөрөг үр дагавар учруулж байна.

Иймд гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрийг баталж гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Ач холбогдол:

Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр батлагдсан нь дараахь ач холбогдолтой.

- Гамшгийн улмаас учрах хор хохирол, түүнийг даван туулах;
- Гамшгийн талаарх мэдээ мэдээллийг ард иргэдэд түргэн шуурхай түгээж, болзошгүй байгалийн аюулыг эртнээс сэрэмжлүүлэх;
- Гамшгийн үед авах зохион байгуулалтын олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн хүний нөөц, аврах ажлын багаж, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх;

- Бүх шатны төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, сайн дурын иргэдийн гүйцэтгэх үүрэг, түншлэл хамтын ажиллагаа тодорхой болж, эрх зүйн зохицуулалт сайжирна.

Мөн гамшгийн даатгалын орчныг бүрдүүлснээр бүс нутгийн болон улс орны хэмжээнд учирсан гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж байгаа төрийн зардал буурах чухал ач холбогдолтой юм.

2008 оны Улсын Их Хурлын сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй нийцэж байгаа эсэх:

Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуульд Ардчилсан намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн “Байгаль ээж” гэсэн хэсэг дэх:

Монгол газрын үзэсгэлэн, цэвэр байгаль, уул ус, ой бэлчээр, говь тал маань монголчууд бидний нэрийн хуудас. Унаган байгаль, газар усаа цэвэр ариунаар үлдээх нь Монгол хүний, Монгол төрийн язгуур бодлого байх ёстой. Мөн сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн улмаас сүйдсэн экосистемийг нөхөн сэргээх ажлыг эхлүүлнэ гэсэн заалттай уг тогтоолын үзэл баримтлал бүрэн нийцэж байна.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт М.Ганбаатар

Утас: 99131522

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас "Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг "Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2011 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хуралдаанаараа хэлэлцэн зарчмын хувьд дэмжихээр шийдвэрлэсэн.

Хууль зүйн үндэслэл:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Засгийн газар Улсын Их Хурлын зөвшөөрлөөр, аймаг нийслэлийн Засаг дарга Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлөөр нийтэд санал болгон үнэт цаас гаргаж болно" гэж, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д "Засгийн газар Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Засгийн газрын үнэт цаас гаргах бүрэн эрхтэй" гэж заасан.

Засгийн газрын үнэт цаас гаргах зорилго нь улсын төсвийн алдагдлыг нөхөх, төрийн албан хаагчид болон иргэдэд олгох орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх юм.

Агуулга:

- Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор **55,443.4 сая /тавин таван тэрбум дөрвөн зуун дөчин гурван сая дөрвөн зуун мянга/хүртэлх** төгрөг;
- Төрийн албан хаагчид болон иргэдэд олгох орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор **72 /далан хоёр/ тэрбум хүртэлх** төгрөг;

Нийт **127,443.4 сая /нэг зуун хорин долоон тэрбум дөрвөн зуун дөчин гурван сая дөрвөн зуун мянга/ хүртэлх** төгрөгийн үнэт цаасыг 2011 оны төсвийн жилд тус тус гаргаж, арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн юм.

Тогтоол батлагдсан нь:

- Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх;
- Төсвийн зардал, санхүүжилтийг цаг хугацаанд нь саадгүй гүйцэтгэх;
- Төрийн албан хаагчид болон иргэдийн нийгмийн баталгааг хангах;
- Санхүүгийн зах зээл дэх орон сууцны зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, орон сууцны зээлийн хүүг бууруулах;
- Барилгын салбарт дэмжлэг болох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Засгийн газрын үнэт цаас гаргах тухай Улсын Их Хурлын тогтоолыг 2011 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Тогтоолыг 2011 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн зөвлөх Д.Бэхбат

Утас: 93135498, 99089799

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор ноолууран түүхий эдээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрлэгчдэд түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгоход зориулан "Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай" тогтоолын төслийг 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг "Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2011 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит хуралдаанаараа хэлэлцэн дэмжихээр шийдвэрлэсэн.

Улсын Их Хурлын байнгын хороо, чуулганы хуралдаанаар хэлэлцэх явцад тогтоолын төслийн нэрийг "Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" болгон өөрчилж, хамрах хүрээг нь өргөжүүлсэн юм.

Засгийн газраас олгох зээлийн зориулалт:

- Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулан ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид 100 /нэг зуун/ тэрбум төгрөг,
- Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд 2011 онд төрөөс олгох мөнгөн урамшуулал болон ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчдэд 50 /тавин/ тэрбум төгрөг,
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд зориулан 150 /нэг зуун тавин/ тэрбум төгрөг.

Уг тогтоолоор нийт 300 /гурван зуун/ тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн.

Тогтоол батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно. Үүнд:

1. Хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж, ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан нэгдүгээр зэргийн хонины ноос, тэмээний ноосны килограмм тутамд 2000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгох;
2. 2011 онд хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгосон мөнгөн урамшуулал болон энэ тогтоолын 3 дахь заалтад заасан Монголбанкны урьдчилан төлсөн хүүгийн зөрүүг буцаан олгохтой холбогдсон зардлыг 2012 оны улсын төсөвт тусгаж, цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;
3. Хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хонины болон тэмээний ноос бэлтгэхэд мөнгөн урамшуулал олгоход тавигдах шаардлага, Засгийн газрын үнэт цаасны санхүүгийн эх үүсвэрийн болон түүхий эд бэлтгэлийн үйл ажиллагааны шат дарааллын бүдүүвчийг тогтоосон холбогдох журмын төслийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу 2011 оны эхний хагаст багтаан батлан мөрдүүлэх;
4. Мал аж ахуйн гаралтай бусад түүхий эдийн дотоодын бэлтгэл болон энэ чиглэлийн үндэсний үйлдвэрүүдийг дэмжихтэй холбогдсон асуудлыг боловсруулан Улсын Их Хурлын 2011 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх.

Үйлдвэрлэгчдэд олгох зээлийн хүүг жилийн 7 хувиас илүүгүй байхаар тооцож, 2011 оны хүүгийн зөрүүг урьдчилан төлөхийг Монголбанкинд үүрэг болгосон бөгөөд цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхаар тогтоосон.

2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн малчин, мал бүхий хувь хүмүүс үндэсний үйлдвэрт тушаасан нэгдүгээр зэргийн хонины ноос, тэмээний ноосны килограмм тутамд 2000 төгрөгийн мөнгөн урамшуулал авах бөгөөд 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн малчин, мал бүхий хувь хүмүүс зөвхөн хоршооны гишүүн болсон тохиолдолд дээрх мөнгөн урамшууллыг үргэлжлүүлэн авах боломжтой юм.

Жижиг дунд үйлдвэрлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулж зээлийн эх үүсвэрт нь 150 тэрбум төгрөгийг нэмж оруулснаар 500 орчим үйлдвэр шинээр байгуулагдан, 30,000 орчим ажлын байр бий болох нөхцөл бүрдэнэ.

Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрт 1 дүгээр зэргийн хонины ноос, тэмээний ноос тушаасан малчдыг урамшуулах механизмыг бий болгосноор үйлдвэрүүд түүхий эдээр бүрэн хангагдахын зэрэгцээ малчдын амьжиргаанд сайнаар нөлөөлөх болно.

Ач холбогдол:

- Монгол Улс малын гаралтай түүхий эдээр хийсэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлох;
- Дотооддоо шинээр ажлын байрыг нэмэгдүүлэх;
- Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, эдийн засгийн бүтцэд бодит хувь нэмэр оруулах юм.

Намын сонгуулийн мөрийн хөтөлбөртэй холбогдох нь:

Ардчилсан намын 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн “Ажилтай, орлоготой, амгалан амьдрал” гэсэн бодлогод заасан “Малчин өрхийн орлогын эх үүсвэрийг тогтвортой байлгахад онцгой анхаарна. Тэргүүний ээлжинд түүхий ноолуурын доод үнийг 30.000 төгрөгнөөс бууруулахгүй, хонь, тэмээний ноосны үнийг 3000-6000 төгрөгт хүргэх бодлого баримтлана” гэсэн зорилтод нийцэж байна.

Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн зөвлөх Д.Бэхбат

Утас: 93135498, 99089799

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн бүлгийн хуралдаанаараа хэлэлцсэн байна.

Уг хуралдаанаар Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг нарийвчлан судлах, бүлгийн санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсан билээ. Үүнд:

1. УИХ-ын гишүүн З.Энхболд - ахлагч
2. УИХ-ын гишүүн Р.Амаржаргал
3. УИХ-ын гишүүн Н.Батбаяр
4. УИХ-ын гишүүн Я.Батсуурь
5. УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
6. УИХ-ын гишүүн Л.Гантөмөр
7. УИХ-ын гишүүн Д.Зоригт
8. УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин
9. УИХ-ын гишүүн С.Эрдэнэ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд уг хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэгт “Үндсэн чиглэлийн биелэлтийн тухай тогтоол гаргана” гэж заасны дагуу Улсын Их Хурлаас анх удаа “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлан гаргалаа.

Энэхүү тогтоолд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2009 оны 79 дүгээр тогтоолын биелэлтийг хангах, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулан 2011 оны 07 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Үндсэн чиглэлийн биелэлтийг үйл

ажиллагааны хэрэгжилтээр дүгнэх, Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг төсөвт тусгаж байх, тэргүүлэх зорилтыг зөв эрэмбэлэх, нэг жилд багтаан хэрэгжүүлэх боломжгүй зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үе шаттайгаар төлөвлөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Мөн Үндсэн чиглэлийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг Улсын Их Хуралд ирүүлж байхыг Үндэсний аудитын газарт үүрэг болгосон бөгөөд уг тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус даалгав.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг 2011 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Э.Мандуул

Утас: 93135491

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2011 оны 05 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн бүлгийн хуралдаанаар хэлэлцэн зарчмын хувьд дэмжсэн.

Үндэслэл:

Засгийн газар Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, салбаруудын хөгжлийн хөтөлбөр, үзэл баримтлал зэрэг бодлогын баримт бичгүүд, яамд, агентлагуудаас ирүүлсэн саналд үндэслэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг боловсруулсан.

Зорилт, арга хэмжээ:

2012 оны үндсэн чиглэл нь Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2012-2015 оны тэргүүлэх чиглэлүүдэд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ашигт малтмал, уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг эхлэх;
- Санхүү, эдийн засгийн хүндрэлийн дараахь сэргэлтийг бататгах, эдийн засгийг төрөлжүүлэн эрчимтэй хөгжүүлэхэд чиглэлсэн томоохон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх;
- Хүн амын амьжиргааны төвшинг дээшлүүлэх чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг үргэлжлүүлэн иргэн бүрт эх орны хувь, хишиг хүртээх;
- Иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх, орлоготой болоход нь төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилтыг баримталсан байна.

Үндсэн чиглэлийн 21 зорилт, 145 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 3.6 их наяд төгрөг, түүний дотор улсын төсвөөс 1 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдаж байгаа юм.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Э.Мандуул

Утас: 93135491

МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2013-2014 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2011 оны 04-р сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2013-2014 оны төсвийн төсөөллийг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн дэмжсэн.

Хууль зүйн үндэслэл: Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Засгийн газар дараа жилийн төсвийн хүрээний мэдэгллийг 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж, мөн зүйлийн 25.3-т “Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгллийг хаврын чуулганаар хэлэлцэж шийдвэрлэнэ” гэж тус тус заасан байдаг.

Онцлог: Сүүлийн жилүүдэд төсвийн төлөвлөлтийг нэг жилийн хугацаагаар хязгаарлалгүйгээр дунд хугацаа буюу гурван жилээр төлөвлөдөг практикт шилжсэн.

Төсвийн төсөл боловсруулах ажил 1 дүгээр улирлаас эхэлдэг болж, төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Засгийн газар (Сангийн яам) бэлтгэн Улсын Их Хурал 5-6-р сард оруулж зөвшөөрүүлдэг болсон нь төсөв зохиох, төсвийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлох үйл ажиллагаанд гарсан нэг дэвшил мөн.

Ач холбогдол:

“Монгол Улсын 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2013-2014 оны төсвийн төсөөллийг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсан нь дараахь нөхцөлийг хангах сайн талтай. Үүнд:

- Дунд хугацаанд төсвийн нийт тэнцлийн алдагдлыг зохистой төвшинд байлгах;
- Эдийн засгийн чадавхи, хөгжлийн нөөц бололцоог бодитой үнэлэх боломжийг бий болгох зэрэг ач холбогдолтой.

МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН
БОЛОН 2013-2014 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Төсөөлөл		
		2012 он	2013 он	2014 он
1.	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ, хувь	16.6	14.8	15.4
2.	Хэрэглээний үнийн өсөлтийн төвшин	9	8	8
3.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	4,176.1	4,601.2	4,823.6
	- ДНБ-д эзлэх хувь	29.8	27.5	24.0
4.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	5,113.5	4,929.8	5,218.0
	- ДНБ-д эзлэх хувь	36.5	29.4	26.0
5.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ	25.2%	-3.6%	5.8%
	- ДНБ-д эзлэх хувь	7.3%	-1.1%	1.4%
6.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-937.4	-328.7	-394.4
	- ДНБ-д эзлэх хувь	-6.7%	-2.0%	-2.0%
7.	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,098.3	1,053.6	1,118.1
	- ДНБ-д эзлэх хувь	7.8	6.3	5.6
8.	Улсын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	7,277.5	7,181.2	7,031.6
	- ДНБ-д эзлэх хувь	51.9	42.9	35.0
9.	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжих зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	218.8	218.8	218.8
	- ДНБ-д эзлэх хувь	1.8%	1.4%	1.1%

“Монгол Улсын 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2013–2014 оны төсвийн төсөөллийг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн зөвлөх Д.Бэхбат

Утас: 93135498, 99089799

МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2010 оны 04-р дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын 2010 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2011 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн зарчмын хувьд дэмжсэн.

Төсвийн бодлогын талаар:

2010 оны төсвийн орлогын төлөвлөлт нь төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрийг дайчлах, татварын тогтвортой орчинг хангах, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

2010 онд нийгмийн халамжийн хөтөлбөрийг хумихгүй байх бодлогыг баримтлан, ингэхдээ эдийн засгийн хямралын үед хүн амын мөнгөн орлогыг бууруулахгүй байх, нэг хүнд ногдох бодит орлого нэмэгдэхгүй байгаа нөхцөлд одоо авч байгаа тэтгэмжийн хамрах хүрээг бууруулахгүй байх, стратегийн орд газруудаас бий болж байгаа орлогыг иргэдэд хуваарилах механизмтай уялдуулан хамтатган шийдвэрлэх арга хэмжээг авч ажилласан.

2010 оны төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, ялангуяа дэд бүтцийн барилга байгууламжийг барих, шинэчлэх, нийгмийн салбарт түлхүү хөрөнгө оруулалт хийх чиглэлийг баримталсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд:

2010 оны нэгдсэн төсвийн орлого гүйцэтгэлээр 3122.5 тэрбум төгрөгт хүрсэн нь 2005 оноос 3.7 дахин, 2009 оныхоос 1.6 дахин өссөн байна.

2010 онд нэгдсэн төсвийн орлогыг 2696.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 3122.5 тэрбум төгрөг болж, төлөвлөгөө 15.8 хувь буюу 426.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2010 оны нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 822.9 тэрбум, нийт тэнцэл 41.7 тэрбум төгрөгийн ашигтай гарснаар төсвийн урсгал тэнцлийн ашиг ДНБ-ний 10.0 хувь, нийт тэнцлийн ашиг ДНБ-ний 0.5 хувьтай тэнцэж байна.

Онцлог:

- Монгол Улсын Засгийн газар, ОУВС-гийн хооронд байгуулсан Стэнд бай хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь санхүү, эдийн засгийн хямралаас гарахад нааштайгаар нөлөөлсөн.
- Нийгмийн баялгийг иргэдэд тэгш хувиарлах ажлыг эхлүүлсэн.
- 2010 оны төсвийн тэцлээр нийт 41.7 тэрбум төгрөгийн ашигтай гарч, 2008, 2009 онд алдагдалтай гарсныг давтаагүй нь энэ жилийн төсвийн гол онцлог болж байна.

Ач холбогдол:

Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын 2010 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсан нь:

1. Төсвийн орлогын суурийг өргөтгөх;
2. Бүртгэл тооцоо, мэдээллийн тогтолцоог сайжруулах;
3. Төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх;
4. Төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэгджээ.

Монгол Улсын 2010 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн

- орлогыг **2,488,490.4** сая /хоёр их наяд дөрвөн зуун наян найман тэрбум дөрвөн зуун ерөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгөөр;
- зарлагыг **2,366,174.0** сая /хоёр их наяд гурван зуун жаран зургаан тэрбум нэг зуун далан дөрвөн сая/ төгрөгөөр тус тус баталлаа.

“Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Э.Мандуул

Утас: 93135491

ХӨЛӨГ ОНГОЦ, ДАЛАЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИУД, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТКОЛД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 05 дугаар сарын 07-ны өргөн мэдүүлсэн “Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай 2001 оны олон улсын Конвенцид нэгдэн орох тухай”, “Хөлөг онгоцны гадаргууг хамгаалах системд хортой бодис ашиглахыг хянах тухай 2001 оны олон улсын Конвенцид нэгдэн орох тухай”, “Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн тухай 2004 оны олон улсын Конвенцид нэгдэн орох тухай”, “Далайн хиймэл дагуулын олон улсын байгууллагын 1976 оны Конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1981 оны Протоколд нэгдэн орох тухай”, “Далайн нэхэмжлэлийн хариуцлагыг хязгаарлах тухай 1976 оны олон улсын Конвенци” болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1996 оны Протоколд тус тус нэгдэн орох тухай асуудлыг Улсын Их Хурал 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж баталсан.

Ач холбогдол:

Эдгээр конвенциудад нэгдэн орох нь байгаль экологи, далайн хүрээлэн буй орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх шаардлагатай асуудлуудад манай улс зохих хувь нэмрээ оруулж, улмаар өөрийн улсын хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бүртгэлээс олох ашиг, орлогыг нэмэгдүүлэх, хөлөг онгоцны эзэмшигчдэд тавих шаардлагыг өндөржүүлэх, үүнтэй холбогдуулан хууль, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох ач холбогдолтой юм.

Далайн хиймэл дагуулын Олон улсын байгууллагын 1976 оны конвенциор далайн тээвэрлэлт хийх явцад хиймэл дагуулын тусламжтайгаар тэдгээрийн аюулгүй байдалд хяналт тавих, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрийн сансарын тоног төхөөрөмжийг ашиглах, Монгол Улсын бүртгэлтэй хөлөг онгоцуудад тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэж байна.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт М.Ганбаатар

БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРААС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ОЛГОХ 500 САЯ АМ.ДОЛЛАРЫН ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙГ АШИГЛАХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын Экспортын зээлийг ашиглах тухай Монгол Улсын Сангийн яам, БНХАУ-ын Экспорт-Импорт банкны хооронд байгуулсан Ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийг Улсын Их Хурал 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа баталсан билээ.

Үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 29 дугаар тэмдэглэл, түүнчлэн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны санал, дүгнэлтийг үндэслэн БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын экспортын зээлийг ашиглах тухай Монгол Улсын Сангийн яам, БНХАУ-ын Экспорт-Импорт банкны хооронд байгуулах Ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 50 дугаар захирамж гарсан бөгөөд Монгол Улсын Сангийн сайд, БНХАУ-ын Экспорт-Импорт банкны дэд Ерөнхийлөгч нар 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдөр гарын үсэг зурснаар зээлийн Ерөнхий хэлэлцээр байгуулагдсан болно.

Бүтэц:

Ерөнхий хэлэлцээрийн дагуу авах 500.0 ам.долларын хөрөнгөөр Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газраас дараахь төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн төсөл /Мах боловсруулах үйлдвэр, хуурай сүү боловсруулах, гурилын үйлдвэр, үр тарианы элеватор байгуулах, бага оврын трактор худалдан авах/;
- Шинэ зууны боловсрол, цахим эрүүл мэнд төсөл;

- Замын олон төвшний огтолцлол төсөл /баруун 4 зам, Баянбүрд, Саппорогийн аюулгүйн тойрог/;
- Автозамын уулзвар, төмөр зам дээгүүрх гүүрэн гарц төсөл /Сонсголон, замын цагдаагийн газрын баруун өмнөх уулзвар, Яармагт шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах/

Төслийн өртөгийн нэгтгэл

№	Хэрэгжүүлэх төслүүд	Өртөг /сая ам.доллар/
1	Хүнс, хөдөө аж ахуйн төсөл	200.0
2	Шинэ зууны боловсрол, цахим эрүүл мэнд төсөл	60.0
3	Замын олон төвшний огтолцлол төсөл	140.0
4	Автозамын уулзвар, төмөр зам дээгүүрх гүүрэн гарц төсөл	100.0
	Нийт	500.0

Зээлийн Ерөнхий хэлэлцээрт зааснаар зээлийн эргэн төлөгдөх хугацаа 20 жил, үүнээс үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 7 жил, жилийн хүү 2 хувь байна.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт Э.Мандуул

Утас: 93135491

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, НҮБ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН САН ХООРОНД БАЙГУУЛСАН “ЗАХ ЗЭЭЛ, БЭЛЧЭЭРИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ” ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан хооронд байгуулсан “Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийг Улсын Их Хурал 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа баталсан билээ.

Үндэслэл, шаардлага:

“Санхүүжилтийн хэлэлцээрийн тухай” Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн “Гарын үсэг зурах эрх олгох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2011 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 2 дугаар захирамж гарч Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан хооронд байгуулах “Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн Санхүүжилтийн хэлэлцээрт гарын үсэг зурах бүрэн эрхийг Сангийн сайд С.Баярцогтод олгосон бөгөөд 2011 оны 06 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурснаар уг зээлийн хэлэлцээр байгуулагдсан.

Уг хэлэлцээр нь “Олон улсын гэрээний тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Онцлог:

“Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл нь “Монгол мал”, “Хоршооллыг хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд төсөлд хамрагдах аймаг сумдын хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэрэгжилтийг дэмжих, хөдөө орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх, хөдөөгийн бага орлоготой иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилготой юм.

Уг төслийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хөдөө аж, ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас 11.5 сая ам.доллартай тэнцэх хэмжээний 7.25 сая ЗТЭ-ийн

хөнгөлөлттэй зээл, Даян дэлхийн байгаль орчны сангаас 1.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийг авах тухай Санхүүжилтийн хэлэлцээрт гарын үсэг зураад байна.

Хэрэгжих газар:

Уг төслийг Архангай, Хөвсгөл, Булган, Хэнтий, Говь-Алтай зэрэг аймгуудийн бололцоотой бүх сумдад хэрэгжих бөгөөд төслийн үргэлжлэх хугацаа нь 5 жил байна.

Төслийн голлон удирдах байгууллага нь ХХААХҮЯ байх бөгөөд төслийн хэрэгжилттэй холбоотой бүхий л хариуцлагыг хүлээнэ.

НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн хөнгөлөлттэй зээлийн жилийн хүү 0,75%-иар, үндсэн зээл ба үйлчилгээний хураамжийг 3 дугаар сарын 01, 9 дүгээр сарын 01-ний өдрүүдэд төлөх ба үндсэн зээлийн төлбөрийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2051 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд хийнэ.

Ач холбогдол:

Уг төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын Засгийн газрын “Монгол мал”, “Хоршооллыг хөгжүүлэх” хөтөлбөрүүдийн хүрээнд төслийн хамрах нутгууд дахь аймаг болон сумын төвүүдийн ядуу өрхүүд, малчдын амьжиргааг дээшлүүлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн референт М.Ганбаатар

Утас: 99131522

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн Санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд 2011 оны 07 дугаар сарын 08-ны өдөр өргөн барьсан билээ.

Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2011 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулах “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн Санхүүжилтийн хэлэлцээрт гарын үсэг зурах бүрэн эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж гарсан бөгөөд Монгол Улсыг төлөөлөн Сангийн сайд гарын үсэг зурсан.

Санхүүжилтийн хэлэлцээр нь Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т заасны дагуу “гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай гэрээ” тул Монгол Улсын Их Хурлаас соёрхон батлах шаардлагатай гэрээ юм.

Үндэслэл, шаардлага:

Монгол Улсын эдийн засгийн хурдацтай, тогтвортой хөгжлийг хангах үүднээс уул уурхайн салбарыг хөгжүүлэх, уул уурхайг дэмжсэн улсын хэмжээний дэд бүтцийн томоохон төслүүдийг хөгжүүлэх нэн тэргүүний шаардлага бий болсон.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктай хамтарч “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийг санаачлан боловсруулсан билээ.

Энэхүү төсөл нь 3 гол бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

1. Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон бусад төрлийн судалгаа боловсруулах санхүүжилт (19.69 сая ам.доллар);
2. ТЭЗҮ болон бусад төрлийн судалгаа боловсруулах Засгийн газрын боловсон хүчин бэлтгэх, гэрээний удирдлага (1.45 сая ам.доллар);
3. Гүний усны менежмент (3.23 сая ам.доллар);

ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Төслийн зардал, бүрэлдэхүүн хэсгээр	Дүн (сая ам.доллар)
Хэсэг 1: Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих 1.1 ТЭЗҮ, бизнес төлөвлөгөө	18.750
Хэсэг 2: Чадавхийг дээшлүүлэх 2.1 Зөвлөх, сургагч	0.938
2.2 Гэрээний удирдлага	0.362
2.3 Туршлагад дүн шинжилгээ хийх	0.085
	1.385
Хэсэг 3: Гүний усны удирдлага 3.1 Гүний усны удирлагын төлөвлөлт	0.375
3.2 Хяналт-шинжилгээний төлөвлөлт	0.900
3.3 Гүний усны хяналт, шалгалт	0.900
3.4 Бараа худалдан авалт	0.360
3.5 Үйл ажиллагааны зардал	0.540
	3.075
Хэсэг 4: Төслийн удирдлага 4.1 Ажилтнуудын цалин	0.424
4.2 Бараа худалдан авах	0.113
4.3 Үйл ажиллагааны зардал (жилийн дундаж)	0.063
	0.600
Суурь зардлын дүн Үнийн хэлбэлзлийн нөөц (5%)	23.810 1.190
ТӨСЛИЙН НИЙТ ӨРТӨГ	<u>25.000</u>

Төслийн хэрэгжих хугацаа: Төсөл нь 2011 оны 06 дугаар сарын 01-нээс 2016 оны 05 дугаар сарын 30-ны хооронд хэрэгжинэ.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Уул уурхайн дэд бүтцийн хөрнгө оруулалтыг дэмжих” төслийн Санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг Монгол Улсын Их Хурлын 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Танилцуулга бичсэн:

Ажлын албаны хуулийн хэсгийн зөвлөх Д.Бэхбат

Утас: 93135498, 99089799

Оюутны талаар авах зарим арга
хэмжээний тухай

Боловсролын тухай хуулийн 43.2.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Оршин суудаг газраасаа 500 километр болон түүнээс хол байршилтай их, дээд сургууль, коллежид зохих журмын дагуу элсэн суралцагсдын өвлийн амралтаар орон нутаг руугаа явсан, ирсэн 2 талын зардлыг холбогдох баримтыг нь үндэслэн авто тээврийн хэрэгслийн тарифаар тооцож Сургалтын төрийн сангаас нөхөн олгож байсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Сангийн сайд

С.БАЯРЦОГТ

Боловсрол, соёл, шинжлэх
ухааны сайд

Ё.ОТГОНБАЯР

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар
авах зарим арга хэмжээний тухай

Үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, боловсруулах үйлдвэрүүдийн чадавхийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд худалдан авахдаа тэргүүн ээлжинд дотоодын үйлдвэрүүдээс худалдан авах бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүд давуу эрхээ ашиглан чанар муутай, стандартын шаардлагад нийцээгүй бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэх, зах зээлийн үнээс хэт өндөр үнэ санал болгох, үгсэн хуйвалдах зэрэг зүй бус үйлдэл гаргасан тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн саналаас татгалзаж, дахин давуу эрх олгохгүй байхаар тогтоосугай.

3. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэх санал ирүүлсэн үндэсний үйлдвэрлэгчдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу давуу эрх олгох зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, Тендерийн үнэлгээний хороонд тухайн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээтэй ажиллаж байгаа мэргэжлийн холбоодын төлөөллийг заавал оролцуулж байхыг төсвийн ерөнхийлөн Захирагч нарт үүрэг болгосугай.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дотооддоо үйлдвэрлэж байгаа зарим бараа, бүтээгдэхүүний импортыг хязгаарлах асуудлыг холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, эрхийн хүрээнд нийцүүлэн боловсруулж Засгийн газрын хуралдаанд энэ оны 4 дүгээр сард багтаан хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай,

Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

5. Энэ тогтоолыг 2014 оныг дуустал дагаж мөрдөхөөр тогтоосугай.

6. Үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг өөрийн хэрэгцээнд худалдан авч, дотоодын үйлдвэрлэлээ дэмжиж байхыг нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдэд уриалсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд

Т.БАДАМЖУНАЙ

ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ДОТООДЫН ҮЙЛДВЭРҮҮДЭЭС ХУДАЛДАН
АВАХ БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

1. Бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн
2. Бүх төрлийн савхин хувцас
3. Бүх төрлийн эсгий
4. Эсгий болон савхин гутал
5. Тусгай хувцас хэрэглэх эрх бүхий зэвсэгт хүчин, дотоодын цэрэг, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон онцгой байдлын ажилтан, гааль, мэргэжлийн хяналт зэрэг улсын байцаагч, байгаль хамгаалагчийн дүрэмт хувцас, хэрэглэл
6. Өвлийн бүх төрлийн үслэг хувцас
7. Бүх шатны боловсролын суралцагчдын дүрэмт хувцас
8. Хөдөлмөр хамгааллын оёмол хувцас, малгай, бээлий
9. Оюутан, сурагчдын болон батлан хамгаалах, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа анги, нэгтгэлүүдийн ширээ, сандал
10. Нэхмэл, оёмол хөнжил
11. Савхин эдлэл (бээлий, бүс, тэлээ)
12. Цүнх
13. Сурах бичиг, сургалтын болон төсвийн байгууллагын бүх төрлийн хэвлүүлэх материал
14. Ширмэл, оёмол гудас
15. Сүлжмэл хувцас, малгай, ороолт
16. Ноос, ноолууран бүтээгдэхүүн
17. Бэлэг дурсгалын бүтээгдэхүүн
18. Сарлагийн хөөвөр, тэмээний ноосон бүтээгдэхүүн
19. Төмс, хүнсний ногоо
20. Сүү, сүүн бүтээгдэхүүн
21. Гурил, гурилан бүтээгдэхүүн
22. Байгалийн гаралтай эрдэсийн дулаалгын материал
23. Тоосго
24. Керамзит, алевролит, перлит, аглопоритын хөнгөн дүүргэгч
25. Өнгөлгөөний замаска
26. Зам, талбайн хавтан, хашилга
27. EPS, XPS хөөсөн полистрол хавтан
28. Хуванцар цонх
29. Хуванцар хаалга

30. PVS, PPR, PE, HPDE хуванцар хоолой
31. Хөнгөн бетон гулдмай
32. Чулуун хөвөн
33. Сэндвич хавтан
34. Дотор ханы магнум гулдмай
35. Төсвийн байгууллагаас зохион байгуулж байгаа хурал, зөвлөлгөөн, семинарын үед хэрэглэх бичиг хэргийн хэрэгсэл, хүнсний зүйл
36. Төсвийн байгууллагуудын бичиг хэргийн хэрэгсэл, цаас, дотоодод үйлдвэрлэдэг бусад материалууд
37. Төсвийн байгууллагын байрны цэвэрлэгээ, үйлчилгээ, ариун цэврийн зориулалттай материалууд
38. Нэг удаагийн тариур, амны хаалт

---oOo---

Журам, чиглэл батлах тухай

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн
6.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журам”-ыг 1 дүгээр, “Хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн байршил, үйл ажиллагааны чиглэл”-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үйлдвэрлэл, технологийн парк болон улсын эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн томоохон бүтээн байгуулалтад оролцож байгаа хөрөнгө оруулагчдыг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Эрдэс баялаг, эрчим хүний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд

Т.БАДАМЖУНАЙ

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд

Д.ЗОРИГТ

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

1. Үйлдвэрлэл, технологийн парк (цаашид “парк” гэх)-ийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Компанийн тухай болон бусад хуулиудын холбогдох заалтуудыг мөрдлөг болгоно.

3. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2.2-т заасан Паркийн хөгжлийн төлөвлөгөөнд дараахь зүйлсийг тусгасан байна:

3.1. Паркт эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний 10-аас доошгүй хувь нь шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулсан, нэвтрүүлсэн, нутагшуулсан техник, технологитой байх бөгөөд цаашид дунд хугацаанд дээрх хувийг үйлдвэрлэл, үйлчилгээ тус бүрээр нэмэгдүүлэх үзүүлэлт он, оноор;

3.2. Паркийн нэгжүүдийн хүний хөгжлийн асуудал;

3.3. Паркт үйлдвэрлэгдэх бүтээгдэхүүний 50 хувиас багагүй хэсэг нь импорт орлох болон экспортын чиг баримжаатай байх бөгөөд цаашид энэ хувийг нэмэгдүүлэх үзүүлэлт он, оноор;

3.4. Паркийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрдэм шинжилгээ, судалгаа явуулах нэгж, технологийн инкубатор, инноваци;

3.5. Паркт эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх Монгол Улсын болон олон улсын стандартуудын нэр;

3.6. Хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын 80-аас доошгүй хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ тухайн салбартаа 5-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай болохыг нотолсон баримт бичиг;

3.7. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.5-д заасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ хөгжих орчинг бүрдүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулах нийт хөрөнгийг нотолсон баримт;

3.8. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн 70 хувиас багагүй хэсгийг паркийн нутаг дэвсгэрт байршуулах асуудал;

3.9. Хуулийн этгээд нь компанийн засаглалын зарчмуудыг хангах нээлттэй, ил тод байдлын тухай дүрэм баталж, мөрдөх асуудал.

4. Паркийн техник, технологийн түвшний үнэлгээ нь Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу хийгдсэн байна.

5. Паркийн удирдлага нь паркийн техник, технологийн түвшний үнэлгээг 2 жил тутамд хийлгэж байна.

6. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.4-т заасны дагуу хөнгөн үйлдвэр болон хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд-паркийн удирдлагатай энэхүү журмын хавсралт 1-д заасан загвар гэрээний дагуу гэрээ байгуулна.

7. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1.2-т заасны дагуу паркийн удирдлага нь энэхүү журмын хавсралт 2-т заасан загвар гэрээний дагуу паркийн нэгжтэй гэрээ байгуулна.

8. Паркийн удирдлагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн явцад гэрээ байгуулсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, жил бүрийн эцэст хоёр тал хамтран дүгнэнэ.

9. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2, энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангаж зохих журмын дагуу гэрээ байгуулан хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу татвар, төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ.

10. Паркийн дэд бүтэц болон хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн төслийг Шинэ бүтээн байгуулалт, Үйлдвэржүүлэх хөтөлбөртэй уялдуулан Хөгжлийн банкны болон олон улсын байгууллага, гадаад орны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нэн тэргүүнд санхүүжүүлэх арга хэмжээ авна.

11. Паркийн байнгын үйл ажиллагаанд мэргэжлийн болон хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд хяналт тавина.

12. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, энэхүү журам болон паркийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн чиглэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

----oO----

“Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын хавсралт 1

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН УДИРДЛАГАТАЙ
БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

20.... он ... сарөдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль болон хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас баталсан журмын хүрээнд паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нэг талаас асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөгөө талаас паркийн удирдлагыг төлөөлж нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх гэрээний хугацаа эхний ээлжинд 5 хүртэл жил байна.

2.2. Гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлж, паркийн техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах талаар гэрээнд заасан хуваарийн дагуу гүйцэтгэж байгааг харгалзан гэрээний хугацааг 5 хүртэл жил сунгаж болно.

Гурав. Паркийн удирдлагын эрх, үүрэг

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч паркийн удирдлага нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан эрх, үүргийн хүрээнд дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ:

- а.
- б.
- в.
- г.

3.2. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2.2, Засгийн газраас баталсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-д заасан нөхцөлийг паркийн удирдлага бүрэн хангаж ажиллана.

3.3. Паркийн удирдлага нь нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн удирдлагатай гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж, паркийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.4. Гэрээний биелэлтийн тайланг жил бүрийн эцэст гэрээ байгуулсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, гэрээг дүгнэх нөхцөлөөр хангана.

3.5. Паркийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан журам, заавар, Монгол Улсын болон олон улсын стандартыг мөрдөн ажиллана.

Дөрөв. Төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

4.1. Паркийн удирдлагаас гэрээний биелэлтийн талаар болон үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах, шаардлагатай тохиолдолд бичгээр тайлан авах эрхтэй.

4.2. Гэрээний биелэлттэй холбоотойгоор паркийн үйл ажиллагаанд шалгалт хийх зорилгоор үйлдвэрийн талбайд саадгүй нэвтэрч, холбогдох бичиг баримттай танилцах эрхтэй.

4.3. Паркийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж ажиллана.

4.4. Гэрээний биелэлтэд хяналт тавьж, жил бүрийн эцэст паркийн удирдлагатай хамтран гэрээг дүгнэнэ.

4.5. Гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байгаа паркийн удирдлагаас гэрээний үүргийн биелэлтийг шаардах болон удаа дараа шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

Тав. Маргаан таслах

5.1. Гэрээний хэрэгжилтийн явцад гарч болзошгүй аливаа маргаантай асуудлыг талуудын хоорондын харилцан зөвшилцөл, тохиролцоогоор шийдвэрлэнэ.

5.2. Маргаантай асуудлыг талууд энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүх, эсхүл Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2. Гэрээний оролцогч талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд гэрээний салшгүй хэсэг болно.

6.3. Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

.....
асуудал эрхэлсэн сайд

Парк /оноосон нэрээр/-ийн
удирдлагыг төлөөлж

.....

.....

“Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын хавсралт 2

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН НЭГЖИЙН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

20.... он ... сарөдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон тусгай зөвшөөрөл эзэмшигч паркийн удирдлагын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

1.2. аймаг /дүүрэг/-т паркийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан паркийн удирдлагыг төлөөлж нэг талаас, нөгөө талаас паркт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг төлөөлж нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Үйлдвэрлэл, технологийн паркт тухайн нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг үндэслэн үйл ажиллагаа эрхлэх гэрээний хугацаа эхний ээлжинд 5 хүртэл жил байна.

2.2. Гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлж, техник, эдийн засгийн үндэслэлийг хэрэгжүүлэх зорилгоор паркийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр гэрээнд заасан үүргээ гүйцэтгэж байгааг харгалзан гэрээний хугацааг 5 хүртэл жил сунгаж болно.

Гурав. Паркийн удирдлагын эрх, үүрэг

3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2.2, Засгийн газраас баталсан “Үйлдвэрлэл, технологийн

паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам"-д заасан нөхцөлийг бүрэн хангаж ажиллана.

3.2. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

3.3. Паркт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллана.

3.4. Гэрээний биелэлтийн тайланг жил бүрийн 4, 7, 10, 1 дүгээр сард паркт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж бүрээр гаргуулан авч дүгнэнэ.

3.5. Паркийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан журам, заавар, Монгол Улсын болон олон улсын стандартыг мөрдөн ажиллана.

3.6. Гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байгаа аж ахуйн нэгжийн гэрээг цуцлах асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

4.1. Паркийн нэгж нь дараахь үйл ажиллагааг эрхэлнэ:

а.

б.

в.

4.2. Паркийн нэгж нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

4.3. Паркийн нэгжийн удирдлага нь гэрээний биелэлт болон үйл ажиллагааны явцын тухай мэдээллийг паркийн удирдлагад энэхүү гэрээний 3.4-т заасан хугацаанд гаргаж өгч, жил бүрийн эцэст хоёр тал хамтран дүгнэнэ.

4.4. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангуулах, холбогдох хуульд заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлнэ.

Тав. Маргаан таслах

5.1. Гэрээний хэрэгжилтийн явцад гарч болзошгүй аливаа маргаантай асуудлыг талуудын хоорондын харилцан зөвшилцөл, тохиролцоогоор шийдвэрлэнэ.

5.2. Хэрэв маргаантай асуудлыг талууд энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүх, эсхүл Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2. Гэрээний оролцогч талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд гэрээний салшгүй хэсэг болно.

6.3. Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Парк /оноосон нэрээр/-ийн
удирдлагыг төлөөлж

Паркийн нутаг дэвсгэрт үйл
ажиллагаа явуулж байгаа аж ахуйн
нэгж /оноосон нэрээр/-ийг төлөөлж:

.....
.....

.....
.....

-----oOo-----

ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН БАЙРШИЛ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

№	Үйлдвэрлэл, технологийн паркийн нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	“Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор” ҮТГ	Дархан-Уул	1/Ган хайлах үйлдвэр: -бөөмцөг (хорголжин) үйлдвэрлэх үйлдвэр; -төмөр замын цагираг үйлдвэрлэх үйлдвэр; -зам, барилгын зориулалттай том хийцийн [хэлбэрийн (швейлер), Н хэлбэр (двух товар)-ийн үйлдвэр; -хуудсан төмрийн үйлдвэр; 2/Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн өргөтгөл, утас цувих цех: -барилгын болон төрөл бүрийн зориулалттай тор хийх үйлдвэр; 3/Машин механизмын эд ангийн төрөлжсөн үйлдвэрлэл; 4/Технологийн судалгааны лаборатори; 5/Металл хийцийн бага оврын үйлдвэрлэл; 6/Газрын тос боловсруулах үйлдвэр; 7/Алт цэвэршүүлэх үйлдвэр зэрэг техник, эдийн засгийн үндэслэлд орсон үйлдвэр, цех.
2	“Эрдэнэтийн	Орхон	-Зэсийн баяжмалыг хайлах,

	зэсийн баяжмал хайлах үйлдвэр” ҮТП		<p>боловсруулах үйлдвэр;</p> <p>-Элементийн хүхрийн үйлдвэр;</p> <p>-Хүхрийн хүчлийн үйлдвэр;</p> <p>-Гидрометаллургийн аргаар катодын зэс гаргах үйлдвэр;</p> <p>-Технологийн судалгааны лаборатори;</p> <p>-Машин механизмын эд ангийн төрөлжсөн үйлдвэрлэл;</p> <p>-Металл хийцийн бага оврын үйлдвэрлэл;</p> <p>-Зэс утасны үйлдвэр зэрэг техник, эдийн засгийн үндэслэлд орсон үйлдвэр, цех.</p>
3	“Багануурын нүүрс-химийн үйлдвэрлэл” ҮТП	Багануур	/Нүүрс-химийн үйлдвэрлэл/ хийн үйлдвэрлэл зэрэг техник, эдийн засгийн үндэслэлд орсон үйлдвэр, цех.
4	“Чойрын металл боловсруулах” ҮТП	Говьсүмбэр	<p>-Эрдэс баялгийг гүнзгий боловсруулах үйлдвэрлэл /Тухайлбал, катодын зэсийг боловсруулан зэсийн цувимал, зэс хоолой, хавтан, зэс утас болон кабель зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх/;</p> <p>-Технологийн судалгааны лаборатори;</p> <p>-Машин механизмын эд ангийн төрөлжсөн үйлдвэрлэл;</p> <p>-Металл хийцийн бага оврын үйлдвэрлэл;</p> <p>-/Нүүрс-химийн үйлдвэрлэл/ хийн үйлдвэрлэл зэрэг техник, эдийн засгийн</p>

			үндэслэлд орсон үйлдвэр, цех.
5	“Сайншанд” ҮТП	Дорноговь	-Эрдэс баялгийг гүнзгий боловсруулах үйлдвэрлэл /Тухайлбал, катодын зэсийг боловсруулан зэсийн цувимал, зэс хоолой, хавтан, зэс утас болон кабель зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх/; -Технологийн судалгааны лаборатори; -Машин механизмын эд ангийн төрөлжсөн үйлдвэрлэл; -Металл хийцийн бага оврын үйлдвэрлэл; -Газрын тос боловсруулах бага оврын үйлдвэр зэрэг техник, эдийн засгийн үндэслэлд орсон үйлдвэр, цех.
6	“Дорнод” ҮТП	Дорнод	-Цайрын баяжмал боловсруулах үйлдвэр; -Газрын тос боловсруулах бага оврын үйлдвэр зэрэг техник, эдийн засгийн үндэслэлд орсон үйлдвэр, цех.
7	“Өмнөд бүс” ҮТП	Тавантолгой	-Коксжих нүүрсний үйлдвэрлэл; -Цементийн үйлдвэр; -Тоосгоны үйлдвэр; -Керамзитийн үйлдвэр; -Технологийн судалгааны лаборатори зэрэг техник, эдийн засгийн үндэслэлд орсон үйлдвэр, цех. -Дулааны нүүрсний үйлдвэрлэл;

“Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд
авто замын талаар авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.6, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт авто замын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шууд гэрээ байгуулан боловсруулах авто замын зураг төслийн ажлын жагсаалтыг 1 дүгээр, Шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх авто замын барилгын ажлын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Шууд гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захиргач Г.Мөнхбаяр нарт даалгасугай.

3. Шууд гэрээгээр гүйцэтгэх ажлуудыг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар нарт тус тус даалгасугай.

4. Авто замын барилгын ажлын технологийн хяналтыг Захиалагчийн хяналтын зардалд багтаан дотоодын зөвлөх компаниар гүйцэтгүүлэн зам, гүүрийн ажлын чанарыг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 51, 55-90 дэх заалтад заасан ажлуудыг хассугай.

6. “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд баригдах авто замын барилгын ажилд тухайн орон нутгийн иргэдийг олноор татан оролцуулж, ажлын байр нэмэгдүүлэхэд шаардагдах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шинээр бий болгосон ажлын байрны талаархи дүнг нэгтгэн Засгийн газарт танилцуулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид даалгасугай .

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Зам, тээвэр, барилга, хот
байгуулалтын сайд

Х.БАТТУЛГА

Сангийн сайд

С.БАЯРЦОГТ

ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛАН БОЛОВСРУУЛАХ АВТО ЗАМЫН
ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Чиглэл	Урт (км)	Өртөг (сая төгрөг)
<i>Нэг. Олон улс, улсын чанартай авто замын зураг</i>		4200,6	10077,1
1	Мандалговь-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто зам	83,0	190,9
2	Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай авто зам	132,6	305,2
3	Ховд-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто зам	190,0	475,0
4	Дашинчилэн-Булган чиглэлийн хатуу хучилттай авто зам	121,0	290,4
5	Наранбулаг-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто зам	51,0	127,5
6	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн хатуу хучилттай авто зам	172,0	430,0
7	Тосонцэнгэлийн баруун талд орших 4 замын уулзвараас Нөмрөг-Сонгино чиглэлийн хатуу хучилттай авто зам	167,0	417,5
8	Өгийнуур-Батцэнгэл-Их Тамир чиглэлийн хатуу хучилттай авто зам	104,0	280,8
9	Баянхонгор-Баянбулаг чиглэлийн хатуу хучилттай авто зам	237,0	568,8
10	Улиастай-Алтай чиглэлийн хатуу хучилттай авто зам	139,0	347,5
11	Баянбулаг-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам	233,0	582,5
12	Улиастай-Дөрвөлжин чиглэлийн хатуу хучилттай авто зам	113,0	259,9
13	Дөрвөлжин-Сархайрхан чиглэлийн хатуу хучилттай авто зам	159,0	365,7

14	Сархайрхан-Ховдын Мянгадын гүүр чиглэлийн хатуу хучилттай авто зам	158,0	363,4
15	Баянхонгор-Баянлиг чиглэлийн хатуу хучилттай авто зам	212,0	508,8
16	Баянлиг-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто зам	293,0	703,2
17	Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто зам	200,0	460,0
18	Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам	290,0	667,0
19	Чойбалсан-Эрээнцав чиглэлийн хатуу хучилттай авто зам	242,0	556,6
20	Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн хатуу хучилттай авто зам	100,0	230,0
21	Алтай-Бугат чиглэлийн хатуу хучилттай авто зам	143,0	343,2
22	Бугат-Бургастай чиглэлийн хатуу хучилттай авто зам	166,0	381,8
23	Нөмрөг-Баянтэс-Арцсуурь чиглэлийн хатуу хучилттай авто зам	199,0	497,5
24	Хутаг-Өндөр-Тэшиг-Бага-Илэнх чиглэлийн хатуу хучилттай авто зам	135,0	337,5
25	Дулаанхаан-Ерөө-Хүдэр чиглэлийн хатуу хучилттай авто зам	113,0	271,2
26	Сэлэнгэ аймгийн Баянгол-Мандал чиглэлийн хатуу хучилттай авто зам	48,0	115,2
<i>Хоёр. Улаанбаатар хотын авто замын зураг төсөл</i>		106,7	3318,5
1	Олимпийн гудамжнаас Нарны зам ба төмөр зам дээгүүр Их Монгол Улсын гудамж руу буух гүүрэн гарц	-	302,0
2	Толгойт-Сонсголонгийн замын уулзварт гүүрэн гарц	-	335,0
3	Ажилчны гудамж, Нарны замын уулзварт гүүрэн гарц	-	306,5
4	Баянбүрдийн аюулгүйн тойрог дээр олон түвшний огтлолцол	-	465,0

5	Саппорогийн аюулгүй тойрог дээр олон түвшний огтлолцол	-	305,0
6	Шинээр барих гол гудамж зам	32,0	502,5
7	Шинээр барих төвийн хэсгийн туслах гудамж зам	5,7	47,0
8	Шинээр барих зүүн хэсгийн туслах гудамж зам	8,0	149,9
9	Шинээр барих баруун хэсгийн туслах гудамж зам	18,5	170,0
10	Шинээр барих хойд хэсгийн туслах гудамж зам	11,6	93,6
11	Алслагдсан 3 дүүргийн доторхи авто зам	15,0	120,0
12	Шинээр барих гүүр, зам доогуурхи байгууламж	-	140,0
13	Явган хүний гүүрэн гарц	8 цэгт	160,0
14	Өргөтгөл, шинэчлэлт хийх гол гудамж зам	6,2	117,0
15	Өргөтгөл, шинэчлэлт хийх туслах гудамж зам	9,7	105,0
	НИЙТ ДҮН	4307,3	13395,6

-----oOo-----

ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АВТО ЗАМЫН БАРИЛГЫН
АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Баригдах авто замууд	Урт (км)	Өртөг (тэрбум төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа
<i>Нэг. Олон улс, улсын чанартай авто зам</i>		1377,4	615,3	
1	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай замын барилга	104	44,7	2011-2012
2	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн хатуу хучилттай замын барилга	129,5	58,3	2011-2012
3	Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн хатуу хучилттай замын барилга	127	57,2	2011-2012
4	Тариалан-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай замын барилга	171	77,0	2011-2012
5	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай замын барилга	94	40,4	2011-2012
6	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн хатуу хучилттай замын барилга	127,1	57,2	2011-2012
7	Алтай-Дарви чиглэлийн хатуу хучилттай замын барилга	263,5	118,6	2011-2012
8	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн хатуу хучилттай замын барилга	181	81,5	2011-2012
9	Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай авто зам	45,3	19,5	2011
10	Дархан-Алтанбулагийн замаас Шаамар-Цагааннуур-Түшиг сум чиглэлийн хатуу хучилттай авто зам	135	60,9	2011-2012
<i>Хоёр. Улаанбаатар хотын авто зам</i>		48,7	98,0	
1	Зүүн 4 замын уулзварт олон түвшний огтлолцол барих	-	28,0	2011-2013
2	Баянзүрхийн товчооноос Богд уулын араар Яармагийн гүүр хүртэлх 17,6 км авто зам	17,6	15,8	2011-2013

3	Нарны замын баруун хэсэг, Төмөр замын вокзалаас Төмөр замын Депогийн уулзвар хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэлт	1,0	1,5	2011
4	Нарны замын зүүн хэсэг, Нарантуул захын урд уулзвараас Чулуун-Овоотын уулзвар хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэлт	2,0	3,1	2011
5	Хасбаатарын гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлт	2,3	3,2	2011
6	Үндсэн хуулийн гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлт (Баруун 4-н замын олон түвшний огтлолцлоос урагш Нарны гүүрэн гарц хүртэлх)	0,3	1,4	2011
7	Сэлбийн хос гүүрийн шинэчлэлт, 58x2 у/м	-	1,2	2011
8	Ажилчны гудамж, Дунд голын доод гүүрийг шинэчлэх, шинээр хос гүүр болгох 35 у/м	-	1,1	2011
9	Энхтайваны өргөн чөлөөний баруун хэсэг, Саппорогийн тойргоос Москвагийн гудамж -Үйлдвэрчний эвлэлийн гудамжны уулзвар-5 шар хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэлт	3,2	6,5	2011
10	Зайсангийн зам, Олимпийн хорооны урд уулзвараас ХААИС-ийн уулзвар хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэлт	1,3	1,4	2011
11	Үйлдвэрчний эвлэлийн гудамжны Баянхошуу чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлт	3,4	4,1	2011
12	Дунд гол үйлдвэрийн гудамж, 19 дүгээр хорооллын арын авто замын шинэчлэлт (Гандийн гудамжнаас баруун тийш Ажилчны гудамж хүртэл)	4,0	6,0	2011
13	Гадна тойруугийн хойд хэсгийн замын 4 дүгээр хэсэг (Дарь-Эхийн авто замаас Ганц худаг-Цайз Цагаан даваа чиглэлд)	1,10	1,0	2011

14	Сүхбаатарын гудамж, Төв шуудангийн зүүн урд уулзвараас хойш Их тойруу-Ногоон нуурын гудамж хүртэлх авто замын шинэчлэлт	2,0	3,0	2011
15	Энхтайваны өргөн чөлөөний зүүн хэсэг, Зүүн 4 замын уулзвараас Офцеруудын ордон-Чулуун-Овоо-Троллейбусны эцсийн буудал хүртэлх авто замын шинэчлэлт	4,5	11,4	2011
16	Чингисийн өргөн чөлөө, Яармагийн гүүрээс Энхтайваны гүүр хүртэлх авто замын шинэчлэлт	4,1	6,1	2011
17	Чингэлтэйн өргөн чөлөө, МТ-ийн ШТС-аас 7-н буудлын эцэс хүртэлх замын өргөтгөл, шинэчлэлт	1,9	3,2	2011
<i>НИЙТ ДҮН</i>		1426,1	713,3	

-----oOo-----

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах,
хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай

Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуулийг үндэслэн Монгол
Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт
тавих журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Сум хөгжүүлэх сангаас олгох
зээлийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус
баталсугай.

2. Засгийн газрын 2001 оны 157 дугаар тогтоолын дагуу
байгуулагдсан Сумын хөгжлийн сангийн үлдэгдэл хөрөнгийг энэ тогтоолын
1 дүгээр зүйлд заасан Сум хөгжүүлэх санд шилжүүлэхийг аймгийн Засаг
дарга нарт даалгасугай.

3. “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт
тавих журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг
дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг
Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
Т.Бадамжунай, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Сумын хөгжлийн сангийн
талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2001 оны 7
дугаар сарын 4-ний өдрийн 157 дугаар тогтоолыг хүчингүй болсонд
тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Сангийн сайд

С.БАЯРЦОГТ

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ,
ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Сумдад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр байгуулах “Сум хөгжүүлэх сан” /цаашид “сан” гэх/-г бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, төсөл сонгон шалгаруулах, сангаас зээл олгох, эргэн төлүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Сан нь Төрийн санд тусгай данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

1.3. Сан нь Төрийн сангаас гадуур данстай байхыг хориглоно.

1.4. Сангийн орлого, зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгагдана.

1.5. Сангийн хөрөнгө нь сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдана.

1.6. Сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлттэй зээл нь дараахь нөхцөлтэй байх бөгөөд зээлийн хүүгийн хэмжээг энэхүү журмын 1.6.1-д заасан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шинэчлэн тогтоож болно.

1.6.1. хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дээд хэмжээ жилд 3 хүртэл хувь;

1.6.2. зээлийн хугацаа нь 36 хүртэл сар байна.

1.7. Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй, эсхүл зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан бол зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд торгууль ногдуулж төлүүлнэ. Торгуулийн хувь хэмжээ,

нөхцөлийг сумын Засаг дарга, зээлдэгч нарын хооронд байгуулах гэрээнд тусгана.

1.8. Сангаас олгох зээлийн хүүгийн орлогын 50 хүртэл хувийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулагдсан төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих ажлыг зохион байгуулах зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулж болно. Үлдэх хувийг сангаас олгох зээлийн эргэлтийн хөрөнгө болгож ашиглана.

1.9. Сангийн хөрөнгийг сумын төсвийн алдагдал нөхөх, төсөвт байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, байгалийн гамшгаас учирсан хохирлыг нөхөн төлөх зэргээр энэхүү журмын 1.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Хоёр. Сангийн хөрөнгийн эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.1. улсын төсвөөс олгох сумын хөгжлийн сангийн эргэлтийн хөрөнгө;

2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;

2.1.3. иргэн, аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлого.

2.2. Санд аймаг, сумын төсвийн хөрөнгө болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хэсгийн хөрөнгөөс хандивлахыг хориглоно.

2.3. Санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзан Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын хамтарсан тушаалаар тогтооно.

Гурав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сангийн хөрөнгөөс зээл олгох, зарцуулах, хяналт тавих, зээлийг эргэн төлүүлэх, тайлагнахтай холбоотой дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн тодорхойлох;

3.1.2. сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлыг харгалзан тухайн санхүүгийн жилд сангаас олгох зээлийн хүүгийн хэмжээг энэ журмын 1.6.1-д заасан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар жил бүр шинэчлэн тогтоох /тухайн санхүүгийн жилд хүүг шинэчлэн тогтоосон нь өмнөх жилүүдэд байгуулсан зээлийн гэрээнд тусгасан хүүг өөрчлөх нөхцөл болохгүй/;

3.1.3. тухайн санхүүгийн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох;

3.1.4. төсөл сонгон шалгаруулахад сумын иргэдийн саналыг авах, түүнийг харгалзан үзэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

3.1.5. сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус ажлын хэсгийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр ахлуулан байгуулна. Ажлын хэсгийг байгуулахдаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргана;

3.1.6. сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шалгалтын дүн, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлэх.

3.2. Сумын Засаг дарга сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. сумын хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах арга хэмжээг авах;

3.2.2. санд ирүүлсэн төслүүдээс энэхүү журмын 3.1.1-д заасан чиглэлд нийцсэн, төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөс шалгаруулсан төсөлд зээл олгох шийдвэр гаргах;

3.2.3. төсөл нь шалгарсан иргэн, аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах;

3.2.4. эргэн төлөгдсөн зээл, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх;

3.2.5. сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

3.2.6. зээлийн хүүгийн орлогоос энэхүү журмын 1.8-д заасан зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн төсвийг боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, сумын жил бүрийн төсөвтэй хамт батлуулах;

3.2.7. сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах,

3.2.8. сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг энэхүү журмын 5.4-т заасан хугацаанд аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлэх.

3.3. Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулна. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг сумын Засаг дарга ахлах бөгөөд зөвлөлийн 3 гишүүн нь тухайн сумын иргэний төлөөлөл байна.

Дөрөв. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулах

4.1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь сангаас зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг сонгон шалгаруулахдаа дараахь шалгуурыг харгалзан үзнэ:

4.1.1. тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх;

4.1.2. хүрэх үр дүн, зорилт нь тодорхой байх;

4.1.3. төслийн үр ашиг, гэрээний хугацаанд зээлээ эргэн төлөх боломжтой байх;

4.1.4. төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, эрсдэлийг даван туулах талаар тусгасан байх;

4.1.5. ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх.

4.2. Сангийн хөрөнгөөс зээл авч төсөл хэрэгжүүлэх этгээд нь дараахь шаардлагыг хангасан байна:

4.2.1. иргэн, аж ахуйн нэгж нь харъяаллын хувьд тухайн суманд бүртгэлтэй байх;

4.2.2. сум хөгжүүлэх сан болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн өргүй байх;

4.2.3. зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлээ хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай байх.

4.3. Энэхүү журмын 4.2-т заасан этгээд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслөө төсөл сонгон шалгаруулах зөвлөлд ирүүлнэ. Төсөл сонгон шалгаруулах хугацааг зөвлөл тогтооно.

4.4. Зөвлөл нь иргэн, аж ахуй нэгжийн ирүүлсэн төслийг энэхүү журмын 4.1, 4.2-т заасан шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, зөвлөлийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Засаг дарга зээл олгох захирамж гаргана.

4.5. Шалгарсан төсөлд зээл олгох тухай шийдвэрийг үндэслэн тухайн төслийг хэрэгжүүлэгч этгээдтэй сумын Засаг дарга зээлийн гэрээг “Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын дагуу байгуулна.

4.6. Зээлийн гэрээг байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлнэ.

4.7. Иргэн, аж ахуйн нэгж олгосон зээлийн хөрөнгө, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд Сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлнө.

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих

5.1. Сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод явуулна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад тухайн сумын иргэд хяналт тавих эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж болно.

5.2. Сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг сумын Засаг дарга хариуцна.

5.3. Энэхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна.

5.4. Сумын Засаг дарга сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, улирлын эхний сарын 10-ны дотор аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлнэ. Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар сумдын тайланг аймгийн хэмжээнд нэгтгэж, улирлын эхний сарын 20-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тайланг улсын хэмжээнд нэгтгэж улирлын эхний сарын 30-ны дотор Сангийн яаманд тус тус хүргүүлнэ.

5.5. Жил бүрийн сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, нэгдсэн дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Сангийн яаманд ирүүлэх асуудлыг аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар хариуцаж ажиллана.

Зургаа. Хариуцлагын тогтолцоо

6.1. Сангийн хөрөнгийг зарцуулах, зээл олгох, зээлийн хөрөнгийг ашиглах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Энэхүү журмын 4.2-т заасан этгээд авсан зээлээ үр ашиггүй зарцуулсан, эсхүл зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлж төлсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгжид сангаас дахин зээл олгохгүй.

6.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, чанаргүй төсөл сонгон шалгаруулсан, тэдгээрт зохих хяналт тавиагүй нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол сумын Засаг даргад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОХ ЗЭЭЛИЙН
ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

20.. он...сар...өдөр

Дугаар...

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү зээлийн гэрээгээр сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, өргөтгөх, сэргээх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр төсөл боловсруулан шалгарсан иргэн, аж ахуйн нэгжид Сум хөгжүүлэх сангаас зээл олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Нэг талаас аймгийн сумын Засаг дарга овогтой /цаашид “зээлдүүлэгч” гэх/ нөгөө талаас аймгийн сумын иргэн, аж ахуйн нэгжийг төлөөлж овогтой /цаашид “зээлдэгч” гэх, хамтад нь “талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 281-286 дугаар зүйлд заасныг үндэслэн /тоогоор, үсгээр/ төгрөгийн зээлийг дор дурдсан нөхцөлөөр олгохоор харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.3. Сангийн хөрөнгөөс зээл авахаар зээлдэгчийн шалгарсан төсөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

2.1. Сангаас олгох /тоогоор, үсгээр/ төгрөгийн зээлийг Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 1.5-д заасны дагуу зориулалтаар зарцуулна.

2.2. Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана. Үүнд:

1. 20.. оны.....дугаар сарын өдөртөгрөг

2. 20.. оны.....дугаар сарын өдөртөгрөг

- 3. 20.. оны.....дугаар сарын өдөртөгрөг
- 4. 20.. оныдугаар сарын өдөртөгрөг гэх мэт

2.3. Зээлдэгч зээлийн үндсэн хүүг сарын..... хувиар тооцож, сар бүрийн эхний 7 хоногийн ажлын өдөрт багтаан сангийн тоот дансанд төлнө.

2.4. Энэхүү гэрээний 2.2-т заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг төлөөгүй, эсхүл зээл төлөх эцсийн хугацаа хэтэрсэн бол зээлийн хугацаанд төлөгдөөгүй үлдэгдэлд үндсэн хүүгээс гадна сарын хувийн торгууль төлнө.

Гурав. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Төсөл хэрэгжүүлэхэд зориулантөгрөгийн зээлийг сарын хувийн хүүтэйгээр олгоно.

3.2. Зээлийн хөрөнгийг зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжийн банк дахь дансанд шилжүүлнэ.

3.3. Авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар төлүүлэх, зохих журмын дагуу зээлийг төлүүлэх шаардлагатай бусад арга хэмжээ авна.

3.4. Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, зээл, хүүгийн төлөлтөд хяналт тавина.

3.5. Зээлдэгчийн хэрэгжүүлж байгаа төслийн явц, байдалтай тухай бүр танилцана.

3.6. Зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ.

Дөрөв. Маргааныг шийдвэрлэх

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг оролцогч талууд харилцан зөвшөөрснөөр шийдвэрлэнэ.

4.3. Энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тав. Бусад зүйл

5.1.....

5.2.....

5.3.....ГЭХ МЭТ

Гэрээний тал:

Зээлдүүлэгч.....

Зээлдэгч.....

.....

.....

----oOo----

Иргэдийг орон сууцжуулах талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “100.000 орон сууц” хөтөлбөрийн хүрээнд иргэдийг орон сууцны зээлд хамруулах санхүүжилтийн загварыг хавсралтаар баталсугай.

2. 50 м²-аас дээшгүй талбай бүхий орон сууц авахаар анх удаа хүсэлт гаргасан иргэдийг жилийн 6 хүртэл хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах харилцааг зохицуулах журмыг боловсруулан хамтран баталж, орон сууцаар хангах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт, хэрэгжилтэд нь байнгын хяналт тавьж ажиллахыг Орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх Үндэсний хорооны дарга, Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

3. Хөгжлийн банкны эх үүсвэрт авсан хүү болон арилжааны банкаар дамжуулан зээлдүүлж байгаа хүүгийн зөрүү, энэ үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

4. Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийг орон сууц худалдан авахад ашиглах хүсэлт гаргасан Монгол Улсын иргэнд төлбөрийн дансны бүртгэл хийх ажлыг зохион байгуулж, орон нутаг дахь захиалгыг тухайн аймгийн Засаг даргын Тамгын газраар гүйцэтгүүлэн, биелэлтийг нэгтгэх арга хэмжээ авахыг “Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК (Ж.Алдаржавхлан)-д үүрэг болгосугай.

5. Ипотекийн хоёрдогч зах зээлийг дэмжих зорилгоор санхүүжилтийн эх үүсвэртэйгээ уялдуулан Монголын Ипотекийн корпорацид урт хугацаат зээлийн санхүүжилт олгох асуудлыг судалж шийдвэрлэхийг Хөгжлийн банк (Ч.Хашчулуун)-нд зөвшөөрсүгэй.

6. Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийг орон сууц худалдан авахад ашиглахтай холбогдуулан шаардагдах хөрөнгийг тухайн жилийн Хүний хөгжил сангийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авч байхыг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

7. Шинэ суурьшлын бүсэд орон сууц барихад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Сангийн сайд

С.БАЯРЦОГТ

Зам, тээвэр, барилга, хот
байгуулалтын сайд

Х.БАТТУЛГА

50 М²–ААС ДЭЭШГҮЙ ТАЛБАЙ БҮХИЙ ОРОН СУУЦ АВАХААР АНХ УДАА ХҮСЭЛТ
ГАРГАСАН ИРГЭДИЙГ ОРОН СУУЦНЫ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛД ХАМРУУЛАХ
САНХҮҮЖИЛТИЙН ЗАГВАР

Орон сууцны зээлийн нөхцөл:

- Банкнаас олгох орон сууцны зээл нь 6 хүртэл хувийн хүүтэй байх.
- 20-30 жилийн хугацаатай байх.
- Иргэнд 1 сая төгрөгийн урьдчилгааг Хүний хөгжлийн сангаас олгох.
- Анх удаа орон сууцны зээл авч байгаа бөгөөд өөрийн орон сууцгүй иргэнд зээл олгох.

Тайлбар:

- Засгийн газраас Хөгжлийн банкинд баталгаа гаргана.
- Хөгжлийн банкнаас Арилжааны банкаар дамжуулан зээлдүүлж байгаа зээлийн хүүгийн зөрүү болон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.



Тайлбар:

1.Иргэн Хүний хөгжил сангаас олгох хишиг, хувийг оролцуулан орон сууцны зээлд хамрагдах хүсэлтээ ОССК (орон нутагт ЗДТГ)-д гаргана.

2.ОССК хүсэлт гаргасан иргэний бүртгэлийг хийж, Арилжааны банкинд шилжүүлнэ.

3.ОССК-ийн саналыг үндэслэн Арилжааны банк иргэнд жилийн 6 хүртэл хувийн хүүтэй орон сууцны зээлийг олгоно.

4.Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг ажлын байраар хангах, орон сууцны зээлд хамруулах зуучлалыг ОССК гүйцэтгэнэ.

Төлөвлөгөө батлах тухай

“Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан биелэлтэд нь хяналт тавьж, явцын талаар Засгийн газарт улирал тутам танилцуулж байхыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд

Д.ЗОРИГТ

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хилийн чанадад амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэх ажилд зориулж 684.300.000 (зургаан зуун наян дөрвөн сая гурван зуун мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын Тэргүүн
шадар сайд

Н.АЛТАНХУЯГ

Өмнөговь аймагт Бүсийн оношилгоо,
эмчилгээний төв байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.10 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн хүн амд эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлгийн хүний нөөц, материаллаг баазад тулгуурлан байгуулсугай.

2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгыг засварлах, өргөтгөх, тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах хөрөнгө болон эмч ажилчдын цалин, тусламж үйлчилгээний зардлын зөрүүг тооцож Монгол Улсын 2012 оны төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөвт тусган хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

3. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тооцон, эмч, сувилагч, мэргэжилтнээр хангах, тэдгээрийг давтан сургах, мэргэшүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2001 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үйлчлэх хүрээний аймаг, сум”-ын жагсаалтын 2 дахь заалтын “Дундговь, Өмнөговь” гэсэн хэсгийг хассугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Эрүүл мэндийн сайд

С.ЛАМБАА

Зарим төрийн өмчит үйлдвэрийн газрыг
төрийн өмчит хувьцаат компани болгон
өөрчлөн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Хэнтий аймгийн “Харгуй”, Сүхбаатар аймгийн “Талын зам” аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газруудыг төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсугай.

2. Өөрчлөн байгуулагдаж байгаа дээрх аж ахуйн нэгжүүдийн дүрмийг баталж мөрдүүлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.ХҮРЭЛБААТАР

Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт “Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Р.Содхүү)-т тус тус даалгасугай.

3. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт алтны шороон ордын ашиглалтын үйл ажиллагаа явуулснаар байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээ, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг тогтоох ажилд шаардагдах зардлыг тооцож Засгийн газрын нөөц сангаас гаргаж, Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт оруулах замаар хөрөнгийг нөхөн бүрдүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Байгаль орчин, аялал
жуулчлалын сайд

Л.ГАНСҮХ

Концессын зүйлийн жагсаалтад
өөрчлөлт оруулах тухай

Концессын тухай хуулийн 6.1.1, 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 94 дэх хэсгийн “Концессын зүйлийн нэр” баганы “Төмөр замын нэгдүгээр үе шат” гэснийг “Төмөр замын нэг, хоёрдугаар үе шат”, “Концессын зүйлийн тодорхойлолт” баганы “Тавантолгой-Цагаансуварга-Зүүнбаян, Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан чиглэлийн 1040 км төмөр зам барих” гэснийг “Тавантолгой-Цагаансуварга-Зүүнбаян, Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан, Нарийнсухайт-Шивээхүрэн, Ухаа худаг-Гашуунсухайт, Хөөт-Тамсагбулаг-Нөмрөг, Хөөт-Бичигт чиглэлийн 2000 км төмөр зам барих” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 4.1.2-ын 2 дахь хэсэгт заасан төмөр замын шугамын царигийн өргөнтэй холбоотой асуудлыг Засгийн газарт оруулж улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төмөр замын нэг болон хоёрдугаар үе шатын концессын зүйлийг холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн 2011 онд багтаан зохион байгуулах арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.ХҮРЭЛБААТАР

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн
мастер төлөвлөгөөг батлах тухай

Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.6-г үндэслэн Монгол Улсын
Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг
хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөнд
заасан арга хэмжээ болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг
жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон
нутгийн төсөвт тусган, гадаад орон, олон улсын банк, санхүүгийн
байгууллагаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт хамруулах, хувийн хэвшлийн
хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх ажлыг зохион
байгуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Сангийн
сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга
нарт даалгасугай.

3. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөөг
Замын-Үүд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн
шийдэлтэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг
Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын Тэргүүн
шадар сайд

Н.АЛТАНХУЯГ

“ЗАМЫН-ҮҮД” ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН МАСТЕР
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ*

1. Судалгааны тайлан
2. Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ
3. Мастер төлөвлөгөө (Тайлбар бичиг)
4. Мастер төлөвлөгөө (Зургийн альбом)
5. Мастер төлөвлөгөө (Баримт бичиг)
6. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө боловсруулах зориулалт бүхий 1:1000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлын тайлан
7. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн суурьшлын бүс, засаг захиргааны бүс, үйлчилгээ, олон нийтийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд зориулсан инженер-геологийн судалгааны тайлан дүгнэлт
8. Дэлхийн эдийн засгийн чөлөөт бүсүүдийн судалгаа
9. Дэлхийн эдийн засгийн тусгай бүсүүдийг харьцуулсан судалгаа болон Лалын Бүгд Найрамдах Пакистан Улсын жишээ
10. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс ба бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлт

* Эх хувиуд нь Засгийн газрын Нууцын архивт хадгалагдаж байгаа.

Мал аж ахуйн салбарын 2011-2012 оны өвөлжилтийн
бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдох үед хэрэглэх аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх доод хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:

2.1. Мал аж ахуйн салбарын 2011-2012 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг малчид, мал бүхий иргэдийн хүчийг нэгтгэж төлөвлөгөө гарган зохион байгуулах, нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлага, ажилтнуудыг хуваарийн дагуу ажиллуулан биелэлтийн явцыг дүгнэж байх.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, явцад нь хяналт тавьж ажиллах.

2.3. Мал сүргийн зун, намрын отрыг сайтар зохион байгуулж, тарга хүч авахуулах.

2.4. Улсын хэмжээнд хээлтүүлэгч малын хүрэлцээ хангалтгүй байгааг харгалзан хээлтүүлэгч нөхөн тавих, худалдан авах ажлыг зохион байгуулан өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн болон эрлийз малд зохиомол хээлтүүлэг хийх арга хэмжээ авах.

2.5. Мал сүргийг халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулгалтад бүрэн хамруулах ажлыг 2011 онд багтаан гурван удаа нэгдсэн байдлаар зохион байгуулах.

2.6. Мал өвөлжүүлж, хаваржуулах хашаа, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор тэдгээрийг засварлах, шинээр хашаа барих, худаг гаргах ажлыг зохион байгуулах.

2.7. Төв, суурин газрын хүн амыг мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах арга хэмжээ авч, 2012 оны хавар хэрэглэх махны нөөц бүрдүүлэх арга хэмжээ авах.

3. Зуны агаарын хэт халалт, хуурайшилт, ган, үерийн улмаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, гамшигт үзэгдэл тохиолдсон үед шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимтэй зохион байгуулж, явцыг нь сар бүр хянан шалгаж, 2011-2012 оны өвөл, хавар отор нүүдлээр өвөлжүүлэх малын тоо, оторлох бэлчээр нутгийг сонгон аймаг, сумын удирдлагын төвшинд хэлэлцээ хийх, отрын нутагт хүрэх нүүдлийн замыг тогтоох зэрэг арга хэмжээг энэ оны 9 дүгээр сард авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ, түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлээ өрхөөрөө болон хамтарч хоршин нөөцлөх, өвлийн хувцас хэрэгсэл, мал аж ахуйн тоног хэрэгслээ засварлах зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлээ сайтар хангахыг малчин өрх, мал бүхий иргэдэд уриалсугай.

6. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, мал өвөлжилтийн бэлтгэлийг ханган, дүнг 2011 оны 11 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2011 оны 192 дугаар
тогтоолын хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ӨВС, ТЭЖЭЭЛИЙН
АЮУЛГҮЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ДООД ХЭМЖЭЭ**

№	Аймгийн нэр	Аймаг, нийслэл		Сум, дүүрэг	
		Өвс (тн)	Тэжээл (тн)	Өвс (тн)	Тэжээл (тн)
1	Архангай	1000	200	100	50
2	Баян-Өлгий	800	200	100	50
3	Баянхонгор	400	200	50	50
4	Булган	1200	300	100	50
5	Говь-Алтай	400	200	50	50
6	Говьсүмбэр	200	100	50	50
7	Дархан-Уул	800	200	100	50
8	Дундговь	500	200	50	50
9	Дорноговь	300	100	50	50
10	Дорнод	1000	200	100	50
11	Завхан	1200	200	100	50
12	Орхон	500	150	100	70
13	Өвөрхангай	1200	300	100	70
14	Өмнөговь	300	100	50	50
15	Сэлэнгэ	1200	400	100	80
16	Сүхбаатар	800	200	100	50
17	Төв	1200	300	100	50
18	Увс	1000	400	80	40
19	Ховд	1000	300	80	40
20	Хөвсгөл	1200	300	100	50
21	Хэнтий	1000	300	100	50
22	Улаанбаатар	400	200	50	50
	Дүн	17600	5050		

Газрын тосны зарим бүтээгдэхүүний
онцгой албан татварын тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний
онцгой албан татварын хэмжээг 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрөөс
эхлэн дор дурдсанаар тогтоосугай:

№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	0.0	0.0	0.0
2	Ханх, Ульханмайхан	0.0	0.0	0.0
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг	0.0	0.0	0.0

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай” Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 182 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд

Д.ЗОРИГТ

Дулааны цахилгаан станцыг барих
концессын гэрээний тухай

Концессын тухай хуулийн 19.1, 29.2, 29.3-т заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Могойн голын дулааны цахилгаан станц барих, ашиглах, төрийн өмчид шилжүүлэх онцгой эрх олгох концессын гэрээ”-г зарчмын хувьд дэмжиж, уг гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зохих журмын дагуу байгуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд зөвшөөрсүгэй.

2. Концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай цахилгаан станцын барилга байгууламжийг угсрах болон барилгын ажлыг эхлүүлэх тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

3. Цахилгаан станц барих газрыг ашиглуулах зөвшөөрөл олгох, орон нутгийн өмчит Могойн голын нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нүүрсээр хангах, дулааны цахилгаан станцын барилгын ажилд дэмжлэг үзүүлж ажиллахыг Завхан аймгийн Засаг дарга Я.Санжмятав, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.ХҮРЭЛБААТАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2011 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын 2011 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд:

1. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төсөл
2. Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуулийн төсөл
3. Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуулийн төсөл
4. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл
5. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
6. Шүүхийн тухай багц хуулийн төсөл
7. Газрын тухай багц хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/
8. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
9. Бусад.

**УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН
БҮЛГИЙН АЖЛЫН АЛБА**

/Зөвхөн албан ажлын хэрэгцээнд/

№	Нэр	Албан тушаал	Өрөө	Гар утас	Өрөөний утас	E-mail
1	Б.Болдбаатар	Ажлын албаны дарга	123	99117692 98110053	328587	boldbator@yahoo.com
Хэвлэл, мэдээллийн хэсэг						
2	Д.Сүндэргүсмаа	Зөвлөх	103	99761020	261630	sunder_davaa@yahoo.com
3	А.Болортуяа	Референт	103	99058998	261630	a_booyo@yahoo.com
Зохион байгуулалтын хэсэг						
4	П.Оюунсүвд	Зөвлөх	105	99195887	266164	suvd1111@yahoo.com
5	Ц.Жавхлан	Референт	103	99026969	266164	javkhlan6969@yahoo.com
6	Б.Оюунтуяа	Референт-оператор	105	95885508	266164	oyuxaib@yahoo.com
Хуулийн хэсэг						
7	Д.Бэхбат	Зөвлөх	121	93135498	260079	Bekhbat_gundai@yahoo.com
8	М.Ганбаатар	Референт	108	93135488	266076	Gan_0408@yahoo.com
9	Б.Одонтуяа	Референт	108	93135497	266076	odontuyaus@yahoo.com
10	Э.Мандуул	Референт	106	93139491	261521	Mr_manduul@yahoo.com
11	Б.Ганхөлөг	Референт	119	93135486	261546	gankhulug@yahoo.com
12	Б.Дагиймаа	Референт	119	88089079	261546	dima1003@yahoo.com

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛГИЙН ГИШҮҮДИЙН ТУСЛАХУУД

/Зөвхөн албан ажлын хэрэгцээнд/

№	Гишүүдийн нэр	Туслахын нэр	Өрөөний утас	Гар утас	E-mail
1	П.Алтангэрэл	Т.Рэнцэнханд	267302	99016183	Tkhanda9947@yahoo.com
2	Н.Алтанхуяг	Ж.Уянга	261074	99853343 92003343	uyanga_1284@yahoo.com
3	Р.Амаржаргал	Г.Батмөнх	260127	93140084	batmunkh@amarjargal.org
		Б.Урантуяа	310127		urantuya1984@yahoo.com
4	Батж.Батбаяр	Ц.Рэнцэнтогтох	260883	98009367 99265607	togtokht@yahoo.com
5	Д.К.Батбаяр	Ш.Бүрэнтогтох	261558	96019761	khunnu_emp@yahoo.com
6	Н.Батбаяр	Н. Мөнхбат	261883	99080443	n1munkhbat@yahoo.com
		З.Сарантуяа		99092539	sarantuya_0810@yahoo.com
				99960806	
7	Я.Батсуурь	Г.Сүх-Очир	329758	88082503	suugii_0825@yahoo.com
8	Г.Батхүү	Оюунцэцэг	264007	99103337	ochka9@yahoo.com
		Махаабариад	260890	95766252	
9	Х.Баттулга	Л.Түвшинжаргал	263249	99248423	tuvshin101@yahoo.com
10	Э.Бат-Үүл	Д.Батмөнх	266364	98112702	dashbat_b@yahoo.com
		Б.Жавзанпагма		99737255	jeegii_1102@yahoo.com
11	Г.Баярсайхан	Болормаа	260469	99872890	bolor_oz@yahoo.com
12	Ц.Баярсайхан	Б.Мэндбаяр	265978	99018225	meed_b@yahoo.com
13	С.Баярцогт	Бүрэнжаргал	262980	99004624	Jangaa79@yahoo.com
14	Л.Болд	Ц.Ариунаа	262623	91004698	anzi_girl@yahoo.com
15	Л.Гансүх	Х.Хэрлэн	261467	91992628	khegii_mn@yahoo.com
16	Л.Гантөмөр	Д.Цоож	267522	99832312	tsooj_davaa@yahoo.com
17	Д.Ганхуяг	Д.Дэлгэрмаа	265303	99191010	deegii_baina@yahoo.com
				99990550	
18	Р.Гончигдорж	Л.Саранцэцэг	262918	99063080	Saraa3080@yahoo.com
		Ономаа		91996985	Onon_0623@yahoo.com
19	Л.Гүндалай	Ш.Энхцэцэг	321986	99081152	-
20	Д.Зоригт	Жавзанпагма	264525	99081218	janna_11@yahoo.com
		Дэмчиг		99064020	demchig2mqj@yahoo.com
21	С.Ламбаа	Хосжаргал	267097	91996037	khosjargal_2004@yahoo.com
22	Д.Одхүү	С.Мөнхбаяр	267006	99115087	smuugii_85@yahoo.com
23	Ч.Сайханбилэг	Д.Сарантуяа	262725	99096599	sarantuya_icta@yahoo.com
		Нарантуяа		99178814	narantuya128@yahoo.com
24	Ц.Сэдванчиг	Б.Оюунтуяа	323146	99156908	oyunaa02@yahoo.com
25	Х.Тэмүүжин	Б.Отгон	262569	50106099	otgoo_317@yahoo.com
26	З.Энхболд	Ж.Батсайхан	261986	96669636	batsaihan99@yahoo.com
27	С.Эрдэнэ	А.Жаргал	262155	91999009	jargalalt@yahoo.com